




СОЁМЬО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.05.21 №20 (10697)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ӨРНӨСӨӨР ...



(Энэ тухай сурвалжилгыг III нүүрнээс уншина уу)

ШИНЭХЭН СОНСОГЧ НАР АНУ-ЫГ ЗОРИНО

АНУ-ын Армийн цэргийн академи "West Point" болон Тэнгисийн цэргийн академи "USNA"-ийн 2020-2024 оны хичээлийн жилд суралцах сонгон шалгаруулалтад тэнцсэн А.Мөнх-Оргил, С.Сайнсанаа нар БХЯ-тай сургалтын гэрээ байгууллаа. Энэхүү арга хэмжээнд БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, ГХАГ-ын мэргэжилтэн, хошууч Б.Мөнхбаяр, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Филип Х.Лью болон А.Мөнх-Оргил, С.Сайнсанаа нарын ар гэрийнхний төлөөлөл оролцов. Энэ үеэр хурандаа



Ө.Эрдэнэ-Очир сонсогч нарт цэргийн академийн сонгон шалгаруулалтад тэнцсэнд нь баяр хүргэж сурлагын өндөр

амжилтыг хүслээ. Сонсогч нар цэргийн академийн сургалт эхлэхээс өмнө тус улсад 14 хоног тусгаарлалтад орох аж.

15000 ШИРХЭГ АМНЫ ХААЛТ ХАНДИВЛАВ



ТИКА-ийн буцалтгүй тусламжаар коронавирусийн цар тахалтай тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Цэргийн төв эмнэлэгт 15000 ширхэг амны хаалтыг хандивлав. Дээрх амны хаалтуудыг Цэргийн төв эмнэлгийн дарга, хурандаа С.Батболдод хүлээлгэн өгсөн бөгөөд ТИКА-ийн хөтөлбөр зохицуулагч Эмрах Устаэмэр, БНТУ-ын Элчин сайдын яамны цэргийн атташе, дэд хурандаа Тамэр Аккам болон албаны бусад хүмүүс байлцлаа.

ТИКА нь Бүгд найрамдах Турк Улсын Соёл, аялал жуулчлалын яамны харьяа

Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг бөгөөд Төв Ази, Зүүн Европ, Кавказ болон шинээр тусгаар тогтносон Балканы орнуудын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор 1992 онд байгуулагдсан аж. Дээрх орнуудтай эдийн засаг, худалдаа, техник, технологи, нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллаж тухайн орнуудын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор төрөл бүрийн салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг. Манай улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэ хугацаанд 550 орчим төсөлд 47

сая долларын буцалтгүй тусламж үзүүлээд байгаа юм. Тухайлбал, УИХ-ын Тамгын газрын хэвлэх цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, УИХ-ын номын санг цахим хэлбэрт шилжүүлэх, ХААИС-ийн харьяа судалгаа, шинжилгээний хүлэмж байгуулах, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 7 дугаар цэцэрлэгт шинээр хоёр бүлгийн өргөтгөлийг барьж иж бүрэн тохижуулах зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэжээ.

Мөн дэлхий нийтэд тархаад байгаа коронавирусийн цар тахалтай тэмцэх нийгмийн өмнө хүлээсэн үүргийн хүрээнд орлогогүй болж хүнд байдалд орсон эмзэг бүлгийг 1000 гаруй айл өрх, асрамжийн газар, төрийн бус байгууллагуудад хүмүүнлэгийн тусламжийг үзүүлж хоол хүнс, эрүүл ахуйн эд материал тараах ажлыг зохион байгуулжээ. Цэргийн төв эмнэлэгт хандивласан дээрх амны хаалтуудыг өмнө нь төслийн хүрээнд байгуулсан оёдлын цехдээ хагас сарын хугацаанд өссөн аж. Түүнчлэн ТИКА-ийн буцалтгүй тусламжаар ШУТИС, МУИС-д байгуулсан 3D принтерийн танхимууддаа коронавирусуээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1100 ширхэг нүүрний хаалтыг хэвлэж эхэлсэн бөгөөд дээжээс нь Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан алба хаагчдад өгөхөөр болсон юм.

ХУРАНДАА Л.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ БОЛГОЛОО

Аугаа Эх орны дайны Ялалтын 75 жилийн ойн өдөр Улаанбаатар төмөр замын төв эмнэлгийг Монгол Улсын хүний гавьяат эмч, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хүндэт төмөр замчин, хурандаа Л.Шаравдоржийн нэрэмжит

болголоо. Тэр бээр Халхын голын байлдаан, Аугаа Эх орны болон Чөлөөлөх дайн хороо, дивизийн эмнэлгийн албаны даргаар үүргээ амжилттай гүйцэтгэж эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөө тэмцэж явсан юм.



Н.Энхболд: МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН ШИНЭ ТӨРЛИЙН ЦЭРЭГТЭЙ БАЙХААР ХУУЛЬЧЛАН ТОГТООЛОО

Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы төгсгөлд эцэслэн батлагдлаа. Монгол Улсын Зэвсэгт хүчний хувьд томоохон шинэчлэл, эрх зүйн орчныг авчирсан гэж үзэж буй уг хуулийн талаар Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.ЭНХБОЛДТОЙ ярилцлаа.

Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь өргөн агуулгатай хууль болсноороо онцлогтой. Учир нь Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхэн хөгжлийнхөө явцад байгаагүйгээр өргөжин хөгжих шинэ эрх зүйн зохицуулалтыг энэ хуульд тусгаж өгсөн юм.

Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг гэсэн хоёр төрлийн цэргээс бүрддэг байсан бол шинэ хуулиар бүтцэд нь барилга-инженерийн, кибер аюулгүй байдлын, тусгай хүчний гэсэн шинэ төрлийн цэрэгтэй байхаар хуульчлан тогтоолоо. Үүнийг дагаад Зэвсэгт хүчний удирдлагын бүтэц, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтад өөрчлөлтүүд орох юм.

Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчин улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд томоохон үүрэг гүйцэтгэж байгааг бид харж, бахархаж байна. Шинээр байгуулагдах Зэвсэгт хүчний барилга-инженерийн цэрэг энэ талбарт ямар үүрэг гүйцэтгэх вэ?

-Манай улсын хувьд өмнө нь Барилгын цэрэг хэмээх бие даасан цэргийн байгууллагатай байсан түүхэн туршлага бий. 1963 оноос улсын хэмжээнд бүтээн байгуулалтын ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгон өрнүүлж, барилга, барилгын материал үйлдвэрлэлийг хурдацтай хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн тогтоолоор Барилгын цэргийн Ерөнхий газрыг Батлан хамгаалах яамны дэргэд байгуулсан байна. Түүнчлэн барилгын цэргийн ангийг олноор байгуулсан байдаг.

1963 онд Барилгын цэрэг байгуулагдсан цагаасаа 1990-ээд оныг хүртэлх хугацаанд 5889 барилга байгууламжийн 17668.4 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэж, 4825 барилга байгууламжийг барьж ашиглалтад хүлээлгэн өгч, 11170.3 сая төгрөгийн барилгын материал, хийц үйлдвэрлэсэн. Түүнчлэн 376 үйлдвэрийн барилга, сум, сангийн аж ахуйн төв, механикжсан ферм, үрийн үтрэм зэрэг аж ахуйн зориулалттай 1397 барилга, Төрийн ордны өргөтгөл, Залуучуудын соёлын төв, олон улсын хүүхдийн "Найрамдал" зуслан, Халх гол, Баянцагааны нуруу, Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын зэрэг нийгэм, соёлын 1110 гаруй барилга байгууламжийг барьж ашиглалтад өгсөн. Мөн хугацаанд барилгын 30 гаруй мэргэжлээр 40 гаруй мянган хүнийг бэлтгэж барилгын салбарын боловсон хүчний хөгжилд томоохон хувь нэмрийг оруулсан байна. Барилга-инженерийн цэргийн үндэс суурийг шинээр тавих ажил 2010 оноос эхэлж Батлан

хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын зүгээс сүүлийн 10 гаруй жилд барилга-инженерийн зургаан анги байгуулсан.

Шинээр байгуулагдсан барилга-инженерийн ангиуд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн сургалтын төвийн цэргийн байр, 339 дүгээр ангийн алба хаагчдын 40 айлын орон сууц, Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн харьяа Халдвартын эмнэлгийн байр, 120, 123, 311, 353 дугаар ангийн соёл, спортын төв мөн 340 дүгээр ангийн албан тушаалын 40 айлын орон сууц, Баян-Өлгий аймгийн Тагнуулын газрын барилга зэрэг бүтээн байгуулалтын томоохон ажлыг хийж гүйцэтгэсэн. 2019 оноос ЗХЖШ-т Бүтээн байгуулалтын асуудал хариуцсан нэгжийг бий болгон ажиллуулснаар цэргийн барилга-инженерийн анги, салбаруудын техник, тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн чадавх, удирдлага, зохион байгуулалт эрс дээшилж бодитой үр дүнд хүрч байна. Зэвсэгт хүчний барилга-инженерийн ангиуд дээрхээс гадна улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд голлох үүрэгтэй оролцож байна. Тухайлбал, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн хүнд даацын авто замын төсөл болон "Халх гол" сумын шинэчлэлийн ажлуудыг хэрэгжүүлж дуусгалаа. Мөн Тавантолгой-Зүүнбан чиглэлийн төмөр замын суурь бүтэц угсрах, доод бүтэц барих бүтээн байгуулалтын ажлыг дурдаж болно.

Дээр дурдсан ажлын үзүүлэлт, үр дүнгээр улс орны стратегийн бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнтэй, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хийж гүйцэтгэх нь өндөр үр дүнтэй болохыг төр, засгийн удирдлага анхааран үзэж, Зэвсэгт хүчний бүтэцэд төрлийн цэрэг байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Барилга-инженерийн цэргийг байгуулснаар Зэвсэгт хүчнийг чадваржуулах, цэргийн алба хаагчдад нийгэмд хэрэгцээтэй мэргэжил эзэмшүүлэх, цэргийн насны залууст цэргийн алба хаах хугацаандаа эх орныхоо бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулахын зэрэгцээ мэргэжил эзэмшиж, мөнгөн хуримтлал үүсгэх зэрэг давхар ач холбогдолтой.

(Үргэлжлэл нь II нүүрт)

Н.Энхболд: МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН ШИНЭ ТӨРЛИЙН ЦЭРЭГТЭЙ БАЙХААР ХУУЛЬЧЛАН ТОГТООЛОО

(Түрүүч нь I нүүрт)

Зэвсэгт хүчний тухай хуульд орсон өөрчлөлттэй уялдуулан шинэ төрлийн цэргийн удирдлагын байгууллага, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, үндсэн үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс техник, тоног төхөөрөмжийн хангалтын асуудлыг шийдвэрлэх зэрэг томоохон ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Гаднын кибер халдлага, түрэмгийллээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг чиглэл бүхий “Кибер аюулгүй байдлын цэрэг”-ийг Монгол Улсын Зэвсэгт хүчинд байгуулах талаар та дурдсан. Энэхүү асуудлыг хуульд тусгах ямар хэрэгцээ, шаардлага байсан бэ?

-Хүн төрөлхтөн хуурай газар, агаар, ус, сансар гэх байгалиас заяасан дөрвөн хэмжээст орон зайд амьдарч ирсэн. Гэтэл сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хүний оюун ухаан, мэдээллийн технологийн дэвшил, түүний хэрэглэнээс бий болсон хийсвэр орон зай буюу “кибер орон зай” бий болж, манай дэлхийг бүхэлд нь бүрхээд байна. Дэлхийн кибер орон зайн аюулгүй байдал үндсэндээ алдагдаж, улс орнуудын аюулгүй байдалд шууд угтаараа заналхийлж байна. Дэлхий дахинд үйлдэгдсэн кибер халдлагын улмаас жилд дунджаар 2 их наяд ам.долларын эдийн засгийн хохирол учирч байна. Халдлагыг нягтлан шинжилж үзвэл 80 орчим хувь нь гэмт хэргийн, эдийн засгийн сэдэлтэй байхад үлдсэн 20 орчим хувь нь улс төрийн зорилготой үйлдэгдэж байна.

Олон улсад кибер орон зайг зэвсэгт тэмцэл хийх боломжтой тав дахь талбар болохыг албан ёсоор зарлан тус талбарт үйл ажиллагаа явуулах Кибер командлалуудыг байгуулж асар их төсөв, хөрөнгө зарцуулсаар ирлээ. Тухайлбал, 2019 онд АНУ 15 тэрбум, БНХАУ 7.3 тэрбум ам.долларын хөрөнгийг кибер цэрэгтээ зарцуулаад байна. Манай улс шиг жижиг орнууд ч кибер цэргийг байгуулах, бүрдүүлэх чиглэлд том гүрнүүдээс дутахгүй анхаарч байна. Жишээлбэл, Эстонийн 1.3 сая хүн амтай жижиг улс хэдий ч НАТО-ийн кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бие даасан кибер командлалтай, 300 орчим кибер цэрэгтэй улс болсон нь томоохон Зэвсэгт хүчинтэй улсуудыг ч энэ чиглэлээр ардаа орхиод байна.

Улс орны кибер орон зайн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт иргэд, төрийн болон хууль, хүчний байгууллагууд шат шатандаа өөр өөрсдийн үндсэн чиг үүргийн хүрээнд оролцох боломжоор хангагдсан байх учиртай. Энэ ч угтаараа гаднын кибер халдлага,

түрэмгийллээс хамгаалах үүргийг Зэвсэгт хүчин хүлээж, түүнийг хэрэгжүүлэх төрлийн цэргийг бий болгож байгаа юм. Зэвсэгт хүчний Жанжин штабын дэргэд Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Зэвсэгт хүчний мэдээлэл холбооны суурь сүлжээг шинэчлэх, нэгдсэн хяналт хийх, кибер халдлагыг мэдрэх, хариу үйлдэл үзүүлэх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг суурилуулах төслийг энэ оны 8 дугаар сард хэрэгжүүлж дуусгахаар ажиллаж байна. Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын төв байрлах Дата төвийг барих шийдвэрийг гаргуулсан. Энэ бүхэн нь “Кибер аюулгүй байдлын цэрэг”-ийг байгуулах үндэс, суурь нь болж өгөх юм.

Энэ хуулиар эрх зүйн үндсийг нь бүрдүүлсэн Зэвсэгт хүчний нэг төрлийн цэрэг болох “Тусгай хүчний цэрэг”-ийн талаар юу хэлэх вэ?

-Орчин үеийн дайн, байлдаан, сүүлийн үед явагдсан зэвсэгт мөргөлдөөнд хийсэн үнэлгээ, дүгнэлтээс харахад “Хосолмол (hybrid, гибрид) дайн”-ы шинж чанарыг агуулсан уламжлалт бус цэргийн аюул, халдлагаас эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эрх ашиг, үнэт зүйлсийг хамгаалах нь улс орны оршин тогтнохуйн аюулгүй байдлын баталгаа болж байна. Энэхүү хосолмол дайны хамгийн аюултай шинж чанар нь дайн ба энхийн ялгаа, зааг нь мэдэгдэхгүй тийм нөхцөлд эсрэг талын зүгээс аливаа улс, үндэстний нийгмийн сэтгэлгээнд тайван замаар нөлөөлж төрийн тогтворгүй байдлыг үүсгэх, цаашлаад үүссэн нөхцөл байдлыг хяналтдаа байлгах, гүнзгийрүүлэх, улмаар үндэстэн дамнасан корпораци, тэдгээрээс санхүүждэг зохион байгуулалттай гэмт хэргийн болон шашны бүлэглэл, тусгайлан бэлтгэгдсэн цэргийн хүчнийг ашиглаж хүссэн үр дүндээ хүрч чаддаг оршиж байгаа юм.

Дэлхийн улс орнууд энэ аюул заналын эсрэг сайтар зориуд бэлтгэгдсэн бүрэлдэхүүнийг ашиглах нь тохиромжтой гэж үзэн стратеги, оперативын тусгай үүрэг гүйцэтгэх томилгоот хүчнийг бий болгон хөгжүүлж байна.

Манай улсын хувьд “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт Зэвсэгт хүчинд тусгай хүчнийг бий болгож, хөгжүүлэх бодлогын зорилтыг дэвшүүлэн, түүнийг энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулаа. Уг хүчнийг Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд одоо байгаа тусгай томилолтын, түргэн байрлах хүчний, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа цэргийн нэгтгэл, ангийг түшиглэн зохион байгуулахад бид төлөвлөн ажиллаж байна.

Д.Цэрэн: НЭГДҮГЭЭР УЛИРАЛД НИЙТ 2665 ӨРГӨДӨЛ ИРҮҮЛСЭН

Төрийн байгууллагын ил тод, иргэдэд нээлттэй байх бодлогын хүрээнд Батлан хамгаалах яам 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар БХЯ-ны ТЗУГ-ын мэргэжилтэн Д.ЦЭРЭНГЭЭС тодрууллаа.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2020 оны нэгдүгээр улиралд хэдэн өргөдөл ирсэн, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Батлан хамгаалах яамны өмнө тавигдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаандаа иргэдээс ирүүлсэн ажил хэрэгч санал, хүсэлтийг судлан тусгах, Засгийн газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, өргөдлийг хүлээн авах, зохих шийдвэр гаргаж, хариу өгөх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан. 2020 оны нэгдүгээр улиралд Батлан хамгаалах яам, харьяа байгууллага, албан тушаалтанд нийт 2665 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол ирүүлснээс 2448 өргөдлийг хуулийн хугацаанд нь, 182 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Агуулгын хувьд, нийгмийн хамгааллын асуудлаар 694, ажлын байртай холбоотой асуудлаар 1642, сургалттай холбоотой асуудлаар 146, ахмад дайчидтай холбоотой асуудлаар ес, бусад асуудлаар 174 өргөдлийг тус тус ирүүлсэн. Бичгээр ирүүлсэн гомдол дийлэнх хувийг эзэлдэг. Энэ оны эхний нэгдүгээр улирлын тухайд л гэхэд 99.4 хувь нь бичгээр ирсэн. Үлдсэн багахан хувь нь цахим, утсаар болон биечлэн уулзаж ирүүлсэн байна.

Дээрх өргөдлүүдээс салбарын удирдах байгууллагад хэдэн хувь нь хаяглагдсан бэ?

-Батлан хамгаалах яамны албан тушаалтанд иргэдээс нийт 164 өргөдөл, гомдол ирүүлснээс 159-ийг нь хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Энэ нь 96.9 үзүүлэлттэй байна. Өргөдлүүдийн 8.5 хувийг Батлан хамгаалахын дэд сайд, 31.1 хувийг Төрийн нарийн бичгийн



дарга, 15.9 хувийг Төрийн захиргааны удирдлагын газарт, 1.8 хувийг бусад газар, хэлтсийн дарга нарт үлдсэн хувийг орон сууцны комисст тус тус хаяглан ирүүлсэн.

Энд албан тушаалын орон сууцныг хувьчлах Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан цаг үеийн мэдээлэл хүргэх нь зөв байх ...

-Байгууллагын мэдлийн албан тушаалын орон сууц эзэмшиж байсан офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, бэлтгэл чөлөөнд гарсан офицер, ахлагч нараас удаа дараа ирүүлж байсан өргөдөл, хүсэлтийн дагуу орон сууцны хувьчлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулсан. Ийнхүү Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 15 орон сууцны ашиглаж байгаа оршин суугчдад хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх болон хувьчлах шийдвэр гарснаар 590 гаруй цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч, иргэд өмчтэй болох нөхцөл бүрдээд байна.

Хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэр их өргөдөл, гомдол ирсэн бэ? Тэдгээрийг хуулийн хугацаанд хэрхэн шийдвэрлэсэн талаар ...

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал, Засгийн

газрын Хэрэг эрхлэх газар, Нутгийн болон захиргааны удирдлагын байгууллага, Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудаас нийт 47 өргөдөл, гомдол шилжиж ирсэн. Тэдгээр өргөдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн ба 100 хувийн үзүүлэлттэй гэж хэлж болно.

Хүлээн авсан өргөдөл, гомдлыг хуулийн хугацааг хүлээхгүйгээр түргэн шуурхай шийдвэрлэх чиглэлд түлхүүтэй анхаарч ажилласан байх ...

-Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөрт “Тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно” гэж заасны дагуу богино хугацаанд шийдэх боломжтой өргөдлийг хуулийн хугацааг хүлээхгүйгээр шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа. Үүний үр дүнд Батлан хамгаалах салбарт ирсэн нийт өргөдлийн 39.6 хувийг 1-7 хоногт, 28.3 хувийг 7-14 хоногт, 16.4 хувийг 14-21 хоногт, 15.7 хувийг 21-30 хоногт тус тус шийдэж хариу өгсөн бөгөөд хуулийн хугацаа хоцроож шийдсэн өргөдөл, гомдол байхгүй гэж ойлгоход болно.

Танд өөр нэмж тодруулах зүйл бий юу?

-Байлдаанд оролцсон ахмад дайчид, түүний гэр бүлээс ирүүлсэн хүсэлтийг судалж, шийдвэр гаргасан талаар мэдээлэл хүргэе гэж бодлоо. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудтай хамтран байлдаанд оролцсон ахмад дайчдын судалгааг гаргаж нэгтгэн сар бүр тодотгол хийдэг. Энэ хүрээнд байлдаанд оролцсон ахмад дайчинд тооцүүлж, үнэмлэх олгох тухай хүсэлт гаргасан гурав, байлдаанд оролцсон ахмад дайчдын ар гэр, үр хүүхдүүдээс орон сууцны дэмжлэг, мөнгөн тусламж хүсэж ирүүлсэн зургаан өргөдлийг судлан үзэж холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-т улс орныг батлан хамгаалах болон эх орныхоо бүтээн байгуулалтад гавьяат үйлсийг бүтээсэн төр, цэрэг, нийгмийн нэрт зүтгэлтнүүдийн баатарлаг, хөдөлмөр үйл ажиллагааг залуу, хойч үеийнхэнд сурталчлах, тэднийг алдаршуулах, дурсгалын цогцолбор байгуулах зэрэг олон талт ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Энэхүү үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасан үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулах үүднээс “Ерөнхий цэрэг ассоциаци” төрийн бус байгууллагаас санаачлан төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Жамсрангийн Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолборыг дурсгалын хөшөө, цогцолборыг аймгийн төвд сүндэрлүүлэн босгож байна.

Түүний хөшөө, дурсгалын цогцолборыг байгуулах энэхүү санаачилгыг Ж.Ёндонгийн үр хүүхдүүд болон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль, Сүхбаатар аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”, “Монгол генерал төв”, “Монгол хурандаа” нийгэмлэг, “Жагсаалч Ж.Ёндон сан”, “Хүндэт харуул” зэрэг төрийн бус байгууллагууд дэмжиж хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/98 дугаар тушаалаар Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолборыг байгуулах ажлыг удирдах ажлын хэсгийг томилсон бөгөөд өнгөрсөн хугацаанд уг дурсгалын хөшөө, цогцолборын зург, бүүдүүвч, орчны тохижилтын

зураг, тооцоо, шаардагдах хөрөнгийн төсөв, хөшөөний загварыг гаргах, газрын асуудлыг нь бүрэн шийдвэрлүүлэх, шав тавих ёслолын ажиллагааг зохион байгуулах зэрэг ажлыг хэрэгжүүлээ.

Уг дурсгалын хөшөө, цогцолборыг байгуулснаар төр, цэргийн нэрт зүтгэлтэн, хурандаа генерал Ж.Ёндон агсны гавьяат үйлсийг сурталчлан мөнхжүүлэх, Сүхбаатар аймгийн төвийн өнгө үзэмж, тохижилтод хувь нэмэр оруулан орон нутгийн иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх амралт, зугаалгын орчныг бүрдүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ахмад үеэрээ бахархах үзлээр хүүхэд, залуучуудыг хүмүүжүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн ажлыг тогтмол зохион байгуулах боломж бүрдэх зэрэг ач холбогдолтой юм.

Хурандаа генерал Ж.Ёндон нь эгэл нэгэн цэргээс сумангийн улс төрийн орлогч, Хүндэт харуулын ротын дарга, БХЯ-ны 1 дүгээр орлогч сайд бөгөөд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, Цэргийн Ерөнхий Дээд Сургуулийн захирал, БХЯ-ны орлогч сайд, Батлан хамгаалах яамны сайдаар ажиллаж байлаа.

Ард түмнээсээ “Жагсаалч-рапорт Ёндон” хэмээх алдрыг хүртсэн тэр бээр 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин бөгөөд түүнд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1970 онд хошууч генерал, 1971 онд дэслэгч генерал, 1982 онд хурандаа генерал цол хүртээсэн юм.

Тэрээр дунд, ахлах, дээд офицерын бүх шатны албан тушаалыг шат дараалан хашиж, үр бүтээлтэй ажиллахдаа 40 насыг дунджаа алхан өндөр мэргэшилтэй залуухан дарга, тухайн үедээ хамгийн залуу генерал хэмээгдсэн онол, улс төрийн өндөр мэдлэгтэй, өргөн цараатай сэтгэдэг, цэргийн удирдлагын онолч, төр, нийгэм, цэргийн зүтгэлтэн байлаа.

Хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалын хөшөө, цогцолборыг байгуулахад шаардагдах хөрөнгийг бид хандив, тусламжийн хэлбэрээр босгон бүрдүүлэх бөгөөд энэхүү бүтээлч ажилд өөрийн хувь нэмрээ оруулахыг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадууд, өдгөө ажиллаж байгаа цэргийн алба хаагч, ажилтан албан хаагчид та бүхэндээ уриалж байна.

Хандивын данс: Төрийн банк, 105200656168 тоот данс, Хурандаа генерал Ж.Ёндонгийн хөшөөний хандив.

Харилцах утас: 91911928, 99277999

“ЕРӨНХИЙ ЦЭРЭГ АССОЦИАЦИ” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Редакцын шууданд

011 дүгээр анги

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас засварт орох шаардлагатай гурван нэгж “Вранглер” загварын суудлын автомашинуудын хийцэд өөрчлөлт оруулж “Хюндай Галлопер” автомашины хөдөлгүүр, хурдны хайрцгийг тааруулж тавилаа. Мөн “Мерседес бенз” загварын автомашины хулдаасан тентийг төмөр казны болгон солих ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

Хошууч Ж.ТӨГСМАНДАХ

150 дугаар анги

Ерөнхий цэргийн мэргэжлийн офицеруудын санаачилгаар ангийн бие бүрэлдэхүүний дунд “Нөхөрсөг буухиа тэмцээн”-ийг зохион байгууллаа. Тэмцээнд найман салбарын 40 гаруй цэргийн алба хаагч таван цэгт гар буу болон автоматын задаргаа, угсаргаа, тэмээн шатаар дамжин хамгаалах иж өмсөх норматив, магазин сумлах норматив, төгсгөлд нь гар дээр суниах, гранат шидэх гэсэн төрлүүдээр авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Мөн эмэгтэй цэргийн алба хаагчдын дунд магазин сумлах нормативын тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээний тэргүүн байрт Миномётын батарей, дэд байрт Мотобуудлагын хоёрдугаар рот, гутгаар байрт Мотобуудлагын дөрөвдүгээр рот, эмэгтэй цэргийн алба хаагчдын төрөлд Мотобуудлагын дөрөвдүгээр ротын ахлагч Б.Нарантуяа нар тус тус шалгарлаа.

Мөн цэргийн алба хаагчдын бие бялдыг хөгжүүлэх, биеийн тамирын бэлтгэлжилтийг хангуулах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор ангийн биеийн тамирын талбайг шинэчлэн, сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулаад байна.

Ахмад Г.БИЛГҮҮН

326 дугаар анги

ЗХЖШ-ын даргын тушаалыг үндэслэн ангийн захирагчийн тушаалаар зэвсэглэл, цэргийн техник, шилт багаж хэрэгсэл, тусгай

тоног төхөөрөмжийг зуны улирлын ашиглалтад шилжүүлэх засвар, техникийн үйлчилгээг хийж ангийн захирагчийн нэрэмжит үзлэгийг явуулсны зэрэгцээ түр хадгалалтад шилжүүлээ.

Мөн Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан ангийн удирдлагаас офицер, ахлагч нарын гэр бүлд “Талархлын захидал”-ыг илгээв.

Ахмад Э.ГАНБАЯР

327 дугаар анги

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг тохиолдуулан “Ялалтын цуурай” цахим уралдааныг зохион байгууллаа. Уран уншлагын төрөлд дэд ахлагч Г.Түвшинбаяр тэргүүн байр, цэрэг-эх орны сэдэвт дууны төрөлд дэслэгч Ж.Саруул туураа байрыг тус тус эзэллээ. Мөн тус анги БНМАУ-ын баатар, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, Маршал Г.К.Жуковын түүх, дайчин замналыг бие бүрэлдэхүүн болон олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Хүндэтгэлийн ерөөн дэх Маршал Г.К.Жуковын алдрын тасалгаанд зэвсэглэлээс гарсан буудлагын зэвсгийг татан авч хүндэтгэлтэйгээр байрлуулав.

Ахмад Д.ГАНБААТАР

336 дугаар анги

“Ерөнхий цэргийн өдөр”-ийг тохиолдуулан сум, орон нутаг руугаа хандсан хэд хэдэн бүтээлч ажлыг өрнүүлээ. Тухайлбал, нийгмийн хариуцлагын хүрээнд Зүүнбаян тосгоны өнгө үзэмжийг сайжруулах, хоггүй цэвэр, эрүүл орчинг бүрдүүлэх зорилгоор төв талбай, автомашины зам дагуух талбайг цэвэрлэж, ногоон байгууламжийг нь сэргээсэн. Мөн ангийн байрлалд эко орчинг бүрдүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 500 гаруй модны суулгацыг бэлтгэхийн зэрэгцээ бие бүрэлдэхүүний дунд сайн үйлсийн аяныг өрнүүлж аймгийн зарим иргэдэд сарын хэрэглээний эд материалыг хандивлав.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Сүүлийн үед иргэдийн хуулийн нимгэн мэдлэг, оюутан, залуусын цэргийн албанаас зайлсхийх санаа, сэдлийг ашиглан иргэдийн “Цэргийн үүрэгтний үнэмлэх” дээр хугацаат цэргийн алба хаасан, “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдсан, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан зэргээр бичилт хийж, хуурамч тамга, тэмдэг ашиглан залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж байгааг иргэд, тэр дундаа цэргийн насны оюутан, залуус, тэдний эцэг, эх, гэр бүлд сээрэмжлүүлж байна. Тухайлбал, 2014 онд “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдсан Чингэлтэй дүүргийн иргэн А нь өөрийн цэргийн үүрэгтний үнэмлэх дээрх тамганы дардсыг хуулбарлан Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль болон Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тамгыг хуурамчаар үйлдэж, хугацаат цэргийн албанаас чөлөөлж өгнө гэж Хан-Уул дүүргийн иргэн Д-гээс гурван удаагийн үйлдлээр 836,000 төгрөг залилан байна. Цагдаагийн

байгууллагаас мөрдөн шалгах явцад үүнтэй адил тохиолдлоор залилангийн гэмт хэргийн хохирогч болсон олон иргэд байгаа нь тогтоогдож, иргэн А нь хуулийн хариуцлага хүлээн ял эдэлж байна.

Иймд иргэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохгүй байх, улмаар цэргийн албанаас зайлсхийсэн гэх үйлдлээр хуулийн хариуцлага хүлээх эрсдэлд орохгүй байх талаар анхаарч, жил бүр явагддаг цэргийн бүртгэлдээ хамрагдаж, зарлан дуудах мэдэгдэл авсан даруйд цэрэг татлагад биечлэн оролцож, “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт болон бусад цэргийн албатай холбоотой санал, гомдол, хүсэлтээ зөвхөн аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын холбогдох албан тушаалтанд биечлэн гаргаж, асуудлаа шийдвэрлүүлж байхыг анхааруулж байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Ирэх онд Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохионо. Энэхүү түүхт ойг угтаж ЗХЖШ-ын даргын тушаалаар хошууч генерал Ж.Бадамбазараар ахлуулсан "Зэвсэгт хүчний гэрэл зургийн альбом" хийх ажлын хэсэг томилогдсон юм. Энэ удаа ЗХЖШ-ын Иргэн-цэргийн харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа О.Хүрэлбаатар, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлагч Л.Амартүвшин, 016 дугаар бригадын алба хаагч О.Мөнхбат болон "Соёмбо" сонины гэрэл зурагчин, ахлах ахлагч Г.Бат-Эрдэнэ миний бие хамрагдсан бүрэлдэхүүн "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож буй Зэвсэгт хүчний ангиудад ажиллаж тэдний ажил үйлсийг гэрэл зурагт баримтжуулан мөнхжүүлэх зорилгыг өвөртлөн алсын замд гарсан юм. "Land cruiser 76" загварын авто машин хөлөглөн замдаа сааталгүй довтолгосоор нар жаргахын алдад Дорнын говийн Зүүнбаян суманд байрлах "Аргалант" зочид буудалд буулаа. Говь нутгийн хаврын сонин хачин цаанаа л нэг гайхалтай. Өглөөхөн налгар нар шарж байсан бол үд мөргөмөгц тавхан алхмын цаана яваа хүн далд ортол шуурах нь энүүхэнд. Ийм байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд өдөр, шөнийг ажралгүй хөдөлмөрлөж байгаа алба хаагчдыг харахад бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрж байв. Эл бүтээн байгуулалтын ажилд оролцож буй алба хаагчдын сэтгэгдлийг сонсоход бүгд л эх орныхоо хөгжил, цэцэглэлтэд гар бие оролцож байгаадаа баяртай байгаа төдийгүй тэр дундаа хугацаат цэргийн алба хаагчид тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болж байгаадаа сэтгэгдэл өндөр байгаагаа хэлж байсан юм.

Улсын Их Хурлаас баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тусгагдсан Дорноговь аймгийн Зүүнбаян сумаас Өмнөговь аймгийн Цогтцэций сум хүртэлх 414,6 км төмөр замын суурийн ажил болон өртөө, зөрлөгийн барилгын ажлыг Зэвсэгт хүчнээс томилогдсон бие бүрэлдэхүүн гүйцэтгэж байгаа. Одоогоор суурийн ажлын 60 гаруй хувийг хийж гүйцэтгээд байгаа ба зөрлөгийн болон ажилчдын байр эхнээсээ ашиглалтад ороход бэлэн болсон аж. Тус барилгуудыг дэд бүтцийн холболттой барьж байгуулсан нь дараа, дараагийн өртөө, зөрлөгийн жишгийг тогтоож өгсөн гэхэд болно.

АЖИЛ ХИЙГ ГЭСЭН ХҮНД АРГА НЬ ОЛДДОГ



Бэлтгэл дэд хурандаа Х.ЗОРИГОО

"Өсвөр насны баялаг бол хүч чадал, гоо сайхан байдаг бол өтөл насны баялаг нь оюун ухааны цэцэглэлт" гэсэн үг байдаг. Дээр хэлсэнчлэн залуу, хойч үедээ алт шиг сургаалаа хэлж, зааварлаж байдаг нэгэн бол Барилгын цэргийн ангиас гавьяаныхаа амралтад гарсан бэлтгэл дэд хурандаа Х.Зоригоо юм. Тэрээр энд Шуурхай удирдлагын бүлгийн барилга хариуцсан инженер, Бетон зуурмагийн үйлдвэрт технологийн инженерийн үүргийг давхар гүйцэтгэж байгаа юм. Х.Зоригоо 1973 онд Улиастайн 016 дугаар нэгтгэлийн 108 дугаар ангид цэргийн албанд татагдаж ажил, амьдралаа барилгын цэрэгтэй холбосон ажээ. Түүнээс хойш тасралтгүй 40 гаруй жил барилгын мэргэжлээр ажиллахадаа 27 жилийг нь барилгын цэрэгт өнгөрүүлжээ. Тэр Барилгын цэргийн үйлдвэр баазад 16 жил ажиллахадаа ээлжийн инженерээс ерөнхий технологич хүртэл дэвшин ажилласан нь түүнийг



Бетон зуурмагийн үйлдвэр

албандаа хоёргүй сэтгэлээр зүтгэдгээс гадна ажлын нэр их туршлагатайг нь тодруулах аж. Х.Зоригоо хэлэхдээ "21 жилийн дараа энэхүү төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцоходоо барилгын цэрэгтэйгээ эргэн холбогдсондоо баяртай байна. Цэргийн алба хаагчидтайгаа эргээд хамтран ажиллахад сэтгэлд ихэд дотно байгаа бөгөөд залуу насандаа эргээд очсон мэт сайхан санагдаж байна. Хүмүүсийн хувьд шагнал гэдэг олон янз байдаг байх. Харин миний хувьд өдий 69 насандаа ийм том бүтээн байгуулалтын ажилд гав шав хийсэн хэдэн залуустайгаа мөр зэрэгцэн хамтран ажиллаж байна гэдэг миний насны хүнд өгч байгаа хамгийн том "шагнал", бас ховорхон тохиолдол юм. Мэдлэг, ур чадвар гэдэг тухайн хүний насан туршийн өмч бөгөөд түүнийгээ бусадтай хуваалцана гэдэг ховор завшаан биз ээ.

МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА АШИГЛАЖ ЧАДВАЛ БИДЭНД ЧАДАХГҮЙ ЗҮЙЛ ҮГҮЙ

Барилгын ажилд суралцаж буй залуу үеийн төлөөллийн нэг нь ахлах дэслэгч Б.Энхбаяр. Тэрээр Зэвсэгт хүчний 017 дугаар ангид алба хаадаг. ҮБХИС-ийн Ахлагчийн сургуулийг 2009 онд Зэвсгийн нярав-засварчин мэргэжлээр төгсөн 016 дугаар ангиас ажлын гараагаа эхлүүлжээ. Дан ганц Зэвсгийн нярав-засварчнаар өөрийнхөө хэмжүүрийг тогтоолгүй 2012-2016 онд Цэргийн командын сургуульд суралцаж хувцасны хангалтын инженерээр төгсөж тус ангидаа ажиллаж байна. Хүнд сурсан зүйл илүүддэггүй гэдэг дээ. Ахлах дэслэгч Б.Энхбаяр олон талаар өөрийгөө хөгжүүлэхийг хүсдэг нь түүний хэрсүү ч гэмээр яриа, тууштай хандлагаас нь илт харагдах юм билээ. Мөн Зэвсэгт хүчний хэмжээнд зохиогддог тэмцээн, уралдаанд



Ахлах дэслэгч Б.ЭНХБАЯР

учиргүй манлайлаад байхгүй ч гэлээ тогтмол идэвхтэй оролцохыг эрмэлздэг гэнэ. Идэвх санаачилга өндөр, олон төрлийн авьяастай энэ залуу офицер Барилгын цэргийн үе үеийн шилдгүүдээс үлгэрлэн тэдний татуулсан дардан замаар зогсолтгүй урагшилж явааг хэлэхэд таатай байна. Тус бүтээн байгуулалтын ажилд

өртөөний барилгын талбайн инженерээр ажиллаж байгаа бөгөөд "Түүхэнд бичигдэх их бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож байгаадаа баяртай байна. Манай орны залуус саруул ухаан, мэдлэг, ур чадвараа ашиглаж чадвал бидэнд чадахгүй зүйл үгүй. Гол нь өөрсдийгөө бүрэн дайчилж, сурч, хөдөлмөрлөх хэрэгтэй гэж боддог" гэсэн юм.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ОРОЛЦОНО ГЭДЭГ ИХ ХУВЬ ЗАЯА



Байлдагч М.ПҮРЭВЖАРГАЛ:

"Хугацаат цэргийн алба хаахын зэрэгцээ бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа алба хаагчдын нэг болсондоо баяртай байна. Би 2019 оны хоёрдугаар ээлжээр Улаанбаатар хотоос хугацаат цэргийн албанд татагдсан. Цэргийн зарлан дуудах хуудас авахын өмнө эмээ, өвөөтэйгөө амьдарч, ресторанд зөөгч хийдэг байсан. Мэдээж зөөгч хийх барилгын ажил хийх тэс ондоо. Эхэндээ бага зэрэг шантарч байсан ч одоо бол алзахгүй болсон. Бүтээн байгуулалтын ажилд оролцох болсноо эмээ, өвөөдөө дуулгахад их баярлаж, бас бахархсан. "Миний хүү эх орныхоо хөгжилд зохих хувь нэмрээ оруулж, албаа сайн хаагаад, их зүйлийг сураад ирээрэй" гэж захисан. Мөн энд ажиллах боломж олгосон ангийн удирдлага, хамт олондоо баярлаж байгаагаа "Соёмбо" сонинор дамжуулан хэлэхэд таатай байна. Монгол Улсын түүхэнд урд өмнө нь хийгдэж байгаагүй томоохон бүтээн байгуулалтад гар бие оролцож байгаадаа сэтгэгдэл өндөр байна.

ӨДӨР БҮР ХИЙЖ БҮЙ АЖИЛДАА ЧИН СЭТГЭЛЭЭ ЗОРИУЛДАГ

Зэвсэгт хүчний бүхий л сургалт бэлтгэл болон олон улсын сургууль, тэмцээн уралдааныг дагадаг нэн чухал амин хэрэгцээ бол цэргийн ар тал. Энд мэдээж тогооч нарын талаар тэмдэглэх



Дэд ахлагч А.ХИШИГСҮРЭН

нь зүйн хэрэг. Тэд үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл ажиллана. Ихэнхдээ магтаал, сайшаалын ард нь хоцорч үлддэг ч ажлаа хийсээр л байдаг. Тэднээр бахархахгүй байхын аргагүй хөдөлмөрч



Төмөр замын зөрлөгийн барилгын ажлын явцаас ...



Ус зайлуулах хоолойны ажил ид үргэлжилж байна



Чулуу бутлуурын үйлдвэрт ажлын бүтээмж өндөр



Төмөр замын зөрлөгийн ажилтнуудын орон сууц

хүмүүс гэсэн бодол надад байнга төрдөг. Зэвсэгт хүчний 331 дүгээр ангиас дэд ахлагч А.Хишигсүрэн энэхүү бүтээн байгуулалтын ажлын үеэр ар талын албанд томилогдон ажиллаж байна. Ангийн хээрийн сургалт, дадлагууд болон Монгол Улс, ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ-2017", "Сэлэнгэ-2019", "Аравт", "Баланс мэжик" зэрэг томоохон сургуульд оролцсон алба хаагчдын халуун хоолыг бэлтгэж байсан. Тэрээр өдөр бүр хийж буй ажилдаа чин сэтгэлээ зориулж, хоолоо хийхийг эрмэлздэг ба бусдын

"Баярлалаа" гэх үгнээс урам авч ядарсан ч ядраагүй мэт ажиллагаа хэлж байсан юм. 2019 онд зохиогдсон 38 дахь удаагийн "Улсын аварга тогооч" шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн нь эзэмшсэн мэргэжилдээ эзэн болсныг нь гэрчлэх биз.

Ийнхүү их говийн гарнизонаас Өмнөговь аймгийн Цогтцэций сум хүртэлх дөрвөн шөнө, дөрвөн өдөр "аяны дөрөө жийж явсан" бидний аялал энд хүрээд өндөрлөсөн юм. **Ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ**

БАРУУН БҮСИЙН АГААРЫН ХИЛЧИД



“Соёмбо” сонины нийтлэлийн бодлогод Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, уншигч-захиалагчдын эрэлт хэрэгцээг хангах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Дээрх зорилтыг бодит ажил хэрэг болгох чухал хөшүүрэг нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа Зэвсэгт хүчний анги, салбар, түүний алба хаагчдын ажил үйлсийн талаарх сурвалжилгыг бэлтгэж олон нийтэд сурталчлах ажил юм. Энэ ч үүднээс өдгөө үүсэн байгуулагдсаныхаа 23 дахь жилийн зунтай золгож буй Зэвсэгт хүчний 325 дугаар ангид ажилласан аяны богцоо задалж байна.

Монгол Улсын баруун бүсийн агаарын хил, орон зайд радиокацын хяналт тавих, агаарын цагийн байдлын мэдээг Агаарын хяналтын төвд дамжуулах үндсэн чиг үүрэг бүхий ангийг байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 113 тоот тогтоол хэрэгжсэнээр Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн түүхийн хуудас нээгджээ.

Биднийг тус ангид очих үед “Covid-19” цар тахалтай холбогду урьдчилан сэргийлэх чиглэлээр багагүй ажлыг хийж, хэрэгжүүлж байгаа нь нүднээ илхэн харагдсан. Тухайлбал, ангийн шалган нэвтрүүлэх байранд өглөө бүр бие бүрэлдэхүүний халууныг хэмжиж хэвшсэн бөгөөд бид ч ялгаагүй “усыг нь уувал, ёсыг нь дагадаг” жамаар биеийнхээ халууныг хэмжүүлж, сольж зүүх хоёр ээлжийн маска шалгуулсан ба ирсэн зорилгоо эхлэн тус ангид нэвтэрсэн. Ангийн захирагч, хурандаа Г.Чулуунзагд, штабын дарга, дэд хурандаа Д.Хишигбаатар нараар ахлуулсан хоёр бүлэг сургуулийн жилийн төгсөлтийн шалгалт авах мөн шалган туслах ажлаар харьяа салбаруудаараа явсан байлаа. Тус ангийн удирдлага болон холбогдох албан тушаалтнууд нь салбаруудаараа тогтмол тойрч, алба хаагчдынхаа ажил, үүргийг шалгахын зэрэгцээ нийгмийн асуудлыг нь өөрсдийнхөө боломж, бололцоогоор шийдвэрлэж ирсэн тухай захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа Б.Ганзам онцолсон. Тэр бээр тус ангид хоёр дахь удаагаа томилогдон ажиллаж байгаа бөгөөд 2011-2013 онд захирагчийн орлогчоор ажиллаж байсан аж. Түүнээс ажил, албандаа баримталдаг

зарчмын талаар тодруулахад “Хүнээ мэдэрч ажиллахыг хичээдэг. Аливаа ажлыг техник, технологи биш хүн хийдэг. Харин үйл ажиллагааг нь хөнгөвчлөх үүднээс техник, технологи ашигладаг. Тиймээс аливаа ажлаас ямар нэгэн үр дүн, тухайн хүнээс албаа гэсэн сэтгэлийг шаардахын тулд эхлээд хүнээ мэдрэх нь зайлшгүй шаардлагатай. Амьдрал өөрөө баялаг тул хүнд юу ч тохиолдож болдог” хэмээн хэлсэн юм.

Хаана ажил хийднэ, тэнд сахилга, хариуцлага алдагдаж байдаг. Тийм ч учраас Зэвсэгт хүчинд ажиллаж байгаа захирагч, дарга нар өөрсдийн удирдлагад ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнийг өдөр бүр томилгоожуулж, үүрэг, зааварчилгаа өгч, араас нь шалгаж явдаг. Ингэснээр ангийн бүхий л үйл ажиллагаа зөвийн явагдаж, өмнөө тавигдсан зорилго, зорилтуудаа бүрэн хангадаг учиртай. Ингэж ажиллаж ажил хийдэг сахилга, хариуцлага алдагдах тохиолдол цөөн биш гардаг. Харин Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын хэмжээнд цэргийн алба, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор явагдсан “Цэргийн алба, сахилгын зөрчилгүй, сэтгэл зүйн хангалтын таатай орчныг бүрдүүлсэн тэргүүний анги” шалгаруулах болзолт уралдаанд 2018 онд тусгай байр, 2019 онд тэргүүн байр эзэлсэн нь тус ангийн үйл ажиллагааны талаар нуришиж, илүү үг бичих шаардлагагүй илтгэнэ. Мөн тус анги 2019 оны үүрэг гүйцэтгэлт, сургалт бэлтгэлийн үнэлгээгээр Агаарын цэргийн командлалын харьяа ангиудаа хошуучилжээ.

Аливаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаа нь санхүүгийн тайлан, тооцоогоор

хуримтлалтай болохыг уриалж, ач тусыг нь ойлгуулж чаджээ. Ингэснээр хүний амьдралд урт ба богино хугацааны төлөвлөж болох болон төлөвлөж болохгүй бэлэн мөнгөний хэрэгцээ, шаардлагыг даван туулах боломжтой болсон бөгөөд нэг хүн дунджаар 1.5 сая төгрөгийн мөнгөн хадгаламжтай аж.

Зэвсэгт хүчний бүхий л анги, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж буй орон нутагтаа хэцүү цагт, хэрэгтэй тусламжийг нь хүргэдэг уламжлалтай. Энэ л жишгийн дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн хамт олон энэ оны гуравдугаар сарын 7-24-ний өдрүүдэд Хөвсгөл, Завхан аймгуудын өвөлжилт хүндэрсэн есөн суманд 6355 километр замыг туулж 77.1 тонн тэжээл, 817 боодол өвс, хоёр тэвш задгай өвсийг тээвэрлэсэн ба өвчтөн, жирэмсэн эхийг татан гаргах, эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс хүргэх, цасанд боогдож суусан автомашиныг чирэх, даваа нээх, айл нүүлгэх, туйлдаж муудсан малуудыг ачих зэрэг ажлуудыг хийжээ. Ингэснээр аймаг, сумын удирдлага, иргэдийн талархлыг хүлээж, иргэн-цэргийн харилцаанд томоохон ахиц гарсан аж.

Дээрх дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэх явцадаа цэргийн сургалт, бэлтгэлийг цалгардуулахгүйгээр батлагдсан төлөвлөгөөний дагуу явуулсан байна. 2019-2020 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 30 километрийн явган маршийг явуулжээ. Тус маршийн үеэр дадлагын долоон цэгийг байгуулж бие бүрэлдэхүүний мэдлэгийг шалгахын зэрэгцээ холбогдох албан тушаалтнуудад давхар сургалтыг явуулсан нь онцлог болжээ. Мөн



Захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа Б.ГАНЗАМ

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас тус ангитай явуулсан байлдааны үүргийн команд штабын сургуульд амжилттай оролцож бие бүрэлдэхүүнийхээ цэргийн хэргийн болон олонийн мэдлэгийг бататгаад авчээ.

Энэхүү ангийг 1997 онд байгуулагдаж байх үеэс ажиллаж байсан бие бүрэлдэхүүн нь тус ангид ашиглагдаж байгаа техник, хэрэгслийг гарын арван хуруу шигээ мэдэрч, сар, улирал, жилдээ хийх ёстой засвар, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг байна. Үүний нэг илрэл нь тус ангийн харьяа салбарууд 2019 онд хорооны төвөөс засварын бүлэг дуудаагүй бөгөөд Радиокацын станцууд нь сул зогсолт хийгээгүй аж. Энэ нь Монгол Улсын баруун бүсэд агаарын нэг ч цөлийг алдалгүй илрүүлж, мэдээллийг нь төв рүү дамжуулан ангийнхаа үндсэн үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэсэн гэсэн үг юм. Ангид

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас тус ангитай явуулсан байлдааны үүргийн команд штабын сургуульд амжилттай оролцож бие бүрэлдэхүүнийхээ цэргийн хэргийн болон олонийн мэдлэгийг бататгаад авчээ.

Энэхүү ангийг 1997 онд байгуулагдаж байх үеэс ажиллаж байсан бие бүрэлдэхүүн нь тус ангид ашиглагдаж байгаа техник, хэрэгслийг гарын арван хуруу шигээ мэдэрч, сар, улирал, жилдээ хийх ёстой засвар, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг байна. Үүний нэг илрэл нь тус ангийн харьяа салбарууд 2019 онд хорооны төвөөс засварын бүлэг дуудаагүй бөгөөд Радиокацын станцууд нь сул зогсолт хийгээгүй аж. Энэ нь Монгол Улсын баруун бүсэд агаарын нэг ч цөлийг алдалгүй илрүүлж, мэдээллийг нь төв рүү дамжуулан ангийнхаа үндсэн үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэсэн гэсэн үг юм. Ангид

шинээр томилогдон ирж байгаа офицер, ахлагч нартай тусгай төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулдаг. Энэхүү сургалтыг дадлага, туршлагатай, ажлаар арван хуруу шигээ мэддэг ахмад ажилтнуудыг дагалдуулах хэлбэрээр зохион байгуулдаг. Ингэснээр онолоор сурч үл болох чадваруудыг эзэмшдэг аж. Тухайлбал, удаан жил болсон техник, хэрэгслүүдэд элбэг тохиолдох гэмтэл, засвар, үйлчилгээг хурдан шуурхай хийж сурна.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн бие бүрэлдэхүүний сургалт, дадлага, бэлтгэлжилт сайн байгаагийн бас нэгэн илрэл нь Улиастай цэргийн хүрээнд явагддаг марш-тактик, тусгай бэлтгэлийн тэмцээнд таван жил дараалан тэргүүн байрыг эзэлж бидний хэлдгээр “тасархай” амжилтыг үзүүлсэн байна. Зөвхөн марш-тактик гэлтгүй спорт, урлаг, соёлын үйл ажиллагаанд тогтмол дээгүүр амжилт үзүүлдэг тухай Ажиллагааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа П.Мэндбаяр бахархан ярьсан юм.

Зэвсэгт хүчний анги, салбар бүр өөрсдийнхөө нөөц бололцоонд тулгуурлан эрвийж, дэргийхээрээ засвар, үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж, материаллаг баазаа сайжруулдаг. Уг хамт олны хувьд өнгөрөгч онд 274 дүгээр тусгай салбар дээр ажиллаж байгаа алба хаагчдынхаа нийгмийн асуудлыг нь шийдэх хүрээнд найман айлын орон сууцыг барьж, ашиглалтад оруулсан ба энэ жил хоёр ч салбар дээрээ тус бүр найман айлын орон сууцыг барихаар төлөвлөж байгаа аж.

Хэдийгээр өөрсдийн нөөц, бололцоогоор бүхнийг хийхийг хүсэвч яагаад ч боломжгүй зүйлс тус ангид ч байв. Тухайлбал, улсын комиссоос тус ангийн штабын байрыг ашиглах боломжгүй гэсэн актыг гаргасан хэдий ч өнөөг болтол ашигласаар байгаа аж. Хэчнээн дотро талаас нь тордож байгаа ч уг барилгын яс нь муудсан тул улирлын шинжтэй хүндрэлүүд гарч, хийсэн засвар, үйлчилгээг нь “урсгачихдаг” байна. Энэхүү асуудлыг шийдэх нэгэн гаргалгаа нь Аймаг, сумын төсөвт суусан байдаг “Хил хамгаалалтад туслах чиглэлийн зардал”-ыг улсын агаарын хилийг сахин хамгаалж байгаа гэсэн үүднээс тус ангийн бүтээн байгуулалтад ашиглаж болмоор. Дээрх “Хил хамгаалалтад туслах чиглэлийн зардал”-ыг ХХЕГ-ын харьяа анги, салбаруудад нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд түлхүү ашигладаг боловч Зэвсэгт хүчний 325 дугаар ангийг Хилийн цэргийн анги биш гэж үзэн хамруулдаггүй нь бас л сонин. Уг нь тус ангийн хамт олон нь хуулиараа ч тэр, үүргээрээ ч мөн адил Монгол Улсын агаарын хилийн халдашгүй дархан байдлыг сахин хамгаалагч агаарын хилчид юм.

Тэргүүний хамт олон

ХАМТ ОЛНЫХОО ХӨДӨЛМӨРӨӨР АРД НЬ ГАРСАН

Төвийн ротын захирагч, ахмад М.БАЯНБИЛЭГ

-18 нас хүрч амьдралдаа хийсэн алхам бүр минь Зэвсэгт хүчний 325 дугаар ангитай салшгүй холбоотой юм. 2004 онд БХИС-ийн Ахлагчийн сургуулийг Радиотелеграфчин мэргэжлээр төгссөн. Төгсөөд тус ангидаа үндсэн мэргэжлээр ажиллаж байгаад 2006 онд БХИС-д Радио-электроникийн инженер мэргэжлээр элссэн суралцаж 2011 онд төгссөн. Мөн л сургуулиа төгсөөд ангидаа өөрийн хүсэлтээр ирж ажилласан. Надад итгэл хүлээлгэж ахлагчийн албанаас офицерын албанд дэвшин суралцах боломжийг олгосон үе үеийн захирагч, дарга нартаа үргэлж талархаж явдаг.

Манай хамт олон 2019 онд онцгой болон тусгай үүргийн цөлийг алдагдалгүй илрүүлж, хорооны төвийн удирдлах байранд мэдээллийг дамжуулан ажилласан. Мөн ротынхоо хичээлийн танхимыг өөрсдийнхөө нөөц, бололцоогоор тохижуулсан, ангийн хэмжээнд болон Агаарын цэргийн командлалын харьяа ангиудын дунд зохиогдсон мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнд ротын бие



бүрэлдэхүүнээс оролцсон цэргийн алба хаагчид өндөр амжилт үзүүлсэн зэрэг олон бүтээлч ажил үйлсийг хамт олныхоо бүтээлч үйл ажиллагаагаар өрнүүлсэн. Бидний ажил үйлсийг ангийн удирдлага өндрөөр үнэлж “2019 оны ангийн тэргүүний хамт олон”-оор шалгаруулан.

ЧАДВАРЫГ ЗӨВХӨН БЭЛТГЭЛ СУРГУУЛИЛТААР ОЛЖ АВДАГ

Төвийн ротын планшет салааны тасгийн захирагч, ахлагч Л.НЯМ-ОСОР

ҮБХИС-ийг 2012 онд Төрийн захиргаа, эрх зүйч мэргэжлээр төгссөн. Уг нь тухайн үед ҮБХИС-ийн цэргийн мэргэжлийн ангид үргэлжлүүлэн суралцах боломж байсан боловч өөрийнхөө “хэнэггүй” зангаасаа болоод ороогүй юм. Тэгтэл 2013 онд Зэвсэгт хүчний 065 дугаар ангид Планшетчин, радиотелеграфчин бэлтгэх дамжаа хичээллэх гэж байгаа, амжилттай төгсөгчдөд цэргийн цол олгож, Зэвсэгт хүчний ангид ажиллуулаа гэдгийг хүнээс сонсоод эргэлзэх зүйлгүй элсэн орж суралцсан. Энэ шийдвэр минь маш зөв байсан гэдэг нь цаг хугацаа өнгөрөх тусам улам батлагдаж байна.

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн “Мэргэжлийн аварга” шалгаруулах цогцолбор тэмцээнд 2017 онд оролцож “Мэргэжлийн аварга планшетчин”-аар шалгарсан. Тус тэмцээн нь жил болгон явагддаг бөгөөд тэргүүн байр эзэлсэн хүн дахин оролцдоггүй журамтай. Иймээс 325 дугаар ангиас оролцох



цэргийн алба хаагчдыг дасгалжуулдаг болсон ба бид багагүй амжилтыг үзүүлсэн. Тодруулбал, өнгөрсөн онд миний дасгалжуулагч ахлагч П.Хажидмаа, Б.Баяржавхлан нар “Мэргэжлийн аварга планшетчин” төрөлд нэг, хоёрдугаар байрт шалгарсан.

Мэргэжлийн бүхэнд өөрийн гэсэн зайлшгүй сурах ёстой чадвар гэж байдаг. Бидний мэргэжлийн хувьд цөлийн мэдээллийг цаг хугацаанд нь хоцрогдоогүй, үнэн зөв буулгах чадварыг шаарддаг. Энэхүү чадварыг зөвхөн бэлтгэл сургуулилтаар олж авдаг. Хийх тусам ажил гарт ордог юм гэж онцолсон.

Нүүрийг бэлтгэсэн ахмад Э.ОЧУУ



“ЦЭРГИЙН УЛС ТӨР, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН ЭВЛЭЛ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАВАН ЖИЛИЙН ОЙД

МЭНДЧИЛГЭЭ



хамгаалах үйлсэд манлайлан оролцож, үе үеийн эх орончдыг төлөвшүүлэхэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж ирсэн билээ.

Өнөөдөр ч нийгмийн шинэ тогтолцооны алдаа, оноотой цаг үеийн дэнсанд иргэдийн оюун санаа, нэн ялангуяа цэргийн алба хаагчдын итгэл үнэмшил, сэтгэл зүйн бат тогтвортой байдлыг хангахад цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтнуудын мэдлэг, мэргэжил, дадлага, туршлага улам бүр өндөр ач холбогдолтой онцлон тэмдэглэе.

Мэргэжил нэгт нийт ажилтнууддаа ажил хөдөлмөрийн өндөр амжилт, эрүүл энх, аз жаргал, сурган боловсруулах насан туршийн гэгцтэй үйлсэд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

“ЦЭРГИЙН УЛС ТӨР, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН ЭВЛЭЛ” ТББ-ЫН ТЭРГҮҮН, БЭЛТГЭЛ ХУРАНДАА Б.ЖУВАА

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙД



“Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл” Төрийн бус байгууллага нь бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад улс төрийн ажилтнууд, Цэргийн Ерөнхий Дээд Сургууль, Цэргийн Нэгдсэн Дээд Сургууль, Цэргийн Их Сургууль, тухайн үеийн нэршлээр Зөвлөлт Холбоот Улсын Львов, Беларусь Улсын Минск хотын Цэргийн сургуулиудыг улс төрийн ажилтан, соёлын ажилтан, сэтгүүлчийн мэргэжлээр суралцаж төгссөн үе үеийн төгсөгчид, оройн сургууль, түр курсээр бэлтгэгдсэн улс төрийн ажилтнууд, иргэдийн санаачилга, идэвх зүтгэл, дэмжлэгтэйгээр 2015 оны 6 дугаар сарын 6-ны өдөр анхдугаар хурлаа хийж үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг баталсан юм.

Энэхүү төрийн бус байгууллага нь удирдах зөвлөлийн 13 гишүүнтэй, тэргүүн, гүйцэтгэх захирал, удирдах зөвлөл, хэвлэл мэдээллийн албатай

бөгөөд 500 гаруй гишүүд, дэмжигчидтэйгээс гадна 16 аймагт салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус эвлэл нь “Цэргийн доторх улс төр, соёл хүмүүжлийн ажлын өв уламжлал, шинэчлэлийг эрхэмлэн дээдэлж, залуу, хойч үед эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, ахмад, залуу үеийн хэлхээ холбоог бэхжүүлэх, ахмад ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, үнэт зүйлсийг нь баталгаажуулах, үнэлэмжийг нь дээшлүүлэх, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, бие бүрэлдэхүүнтэй зохиох соёл хүмүүжлийн ажлын агуулга, хэлбэрийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг төрийн байгууллага, гишүүд, дэмжигчидтэйгээ хамтран хэрэгжүүлж байна.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА-ОНЦЛОХ 10 АЖИЛ

➢ “Цэргийн соёл хүмүүжлийн ажилтны өдөр”-ийг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу дөрвөн удаа зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэсэн. Энэ ажилд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад ажилтнууд, Зэвсэгт хүчний анги, салбаруудад ажиллаж байгаа соёл хүмүүжлийн ажилтнуудыг оролцуулан Цэргийн Соёлын төв өргөө, Монгол цэргийн музей, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байрлалд зохион байгуулж явууллаа.

➢ Монгол цэргийн музейн Төрөл мэргэжлийн цэргийн түүхийн үзүүлэлийн танхимд Цэргийн улс төрийн байгууллагын түүхэн замналыг харуулсан иж бүрэн тасалгааг шинээр тохижуулж музейн сан хөмрөгийг баяжуулав. Энэхүү тасалгааг анхны Сурган боловсруулах газрын тамга, түүхэн баримтууд, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад улс төрийн ажилтнуудын нэрс, алдар гавьяатнууд, Улс төрийн газрыг удирдаж байсан 24 хүний гэрэл зураг, ахмад ажилтнуудын дурсгалын зүйлс, соёл хүмүүжлийн ажилд ашиглагдаж байсан техник хэрэгсэл, Улс төрийн газрын даргаар олон жил ажиллаж байсан дэслэгч генерал агсан Д.Ёндондүйчирийн өмсөж байсан цэргийн дүрэмт хувцас, албаны баримт бичгүүд, Цэргийн Ерөнхий Сургуулийн Улс төрийн ангийг төгссөн үнэмлэх зэрэг эд өлгийн зүйлүүдээр баяжуулсан юм.

➢ Халхын голын байлдаанд эрэлхэг гавьяа байгуулсан БНМАУ-ын баатар, батарейны улс төрийн удирдагч Л.Гэлэгбаатарын гавьяат үйлсийг мөнхжүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ... дугаар дивизионы цэргийн байранд хүндэтгэлийн тасалгааг бүрэн хэмжээгээр нь тохижуулан ангид нь хүлээлгэн өгсөн.

➢ ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхим байгуулагдсаны 50 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын тусгай төлөвлөгөөг сургуулийн удирдлага, тэнхимийн багш нар, үе үеийн төгсөгчидтэй хамтран боловсруулсан ба улс, батлан

хамгаалах салбарын хэмжээнд уг ойг зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэв. Энэхүү ажилд Монгол Улсын Ерөнхий сайд болон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүн өндөр ач холбогдол өгч оролцсон юм.

➢ Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран эрдэм шинжилгээ, онол-практикийн хурал, хэлэлцүүлгүүдийг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Тэдгээрээс:

-“Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн байгууллагын уламжлал, шинэчлэл, тулгамдсан асуудал” сэдвээр 2016 оны 2 дугаар сард;

-“Өнөөгийн нийгмийн хөгжилд хүний оюун санааны хүчин зүйлийн гүйцэтгэх үүрэг” сэдвээр 2017 оны 12 дугаар сард;

-“Халхын голын байлдаанд Цэргийн улс төрийн байгууллага, улс төрийн ажилтнуудын гүйцэтгэсэн үүрэг” сэдвээр 2019 оны 5 дугаар сард зохион байгуулсан хурлыг онцолж байна.

➢ Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн Аюулгүй Байдлын Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн тэнхимээс төрөн гарсан Монгол Улсын гавьяат багш, Шинжлэх ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа Г.Мягмаржав, Гавьяат багш, доктор, профессор, чөлөөнд байгаа дэд хурандаа Б.Галиндэв, Гавьяат багш, ҮБХИС-ийн анхны хүндэт доктор, чөлөөнд байсан хурандаа Б.Банзрагч, Гавьяат багш, профессор, чөлөөнд байгаа хурандаа Н.Ядмаа, доктор, профессор Б.Дуламсүрэн нарын хөдөлмөр, зүтгэлийг алдаршуулан “Номын баяр-Багшийн алдар” сэдэвт цуврал өдөрлөг, дурсамж-уулзалтыг зохион байгуулж хүндэтгэл үзүүлэв.

➢ Зэвсэгт хүчний Жанжин штаб, Иргэн-цэргийн харилцааны хэлтэстэй хамтран Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний ангиудын соёл хүмүүжлийн ажилтнууд, сэтгэл зүйчдийг хамруулсан “Бидний ажил ба мэргэжил” сэдэвт уулзалт, өдөрлөгийг Монгол цэргийн музейд

зохион байгуулав. Энэхүү ажлын үеэр Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын мэргэжлийн бүжигчид үзүүлэх хичээлийг явуулсан ба ахмад улс төрийн ажилтнууд арга туршлагаа ярьсны зэрэгцээ хэргийн ухуулах цэгийг шинээр төхөөрөмжлөн үзүүлэв.

➢ “Төрийн бус байгууллагын нэг өдөр” арга хэмжээг Зэвсэгт хүчний 120, 032 дугаар ангид тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд тус ангидын бие бүрэлдэхүүнд соён гэгээрүүлэх лекц, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчдийн хэсэгчилсэн тоглолтыг зохион байгуулсан ба ангийн номын санд ном, тогтмол хэвлэлийг хандивлан офицер, ахлагч нартай ярилцлага явуулсан нь үр дүнтэй ажил болсон юм.

➢ Ном сурталчлан таниулах, бэлэглэх, хандивлах, худалдах арга хэмжээг Цэргийн соёлын төв өргөөнд анх удаагаа зохион байгуулсан ба “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-нд 100 гаруй номыг хандивласан. Энэ арга хэмжээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний “Соёмбо” сонины редакт, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль, Шинжлэх Ухаан, Техникийн Их Сургууль, тэдгээрийн номын сангууд идэвхтэй хамтран оролцсон. Мөн Монголын Ардын Армийн Улс төрийн газрын даргаар ажиллаж байсан хошууч генерал Ж.Цэнд-Аюуш, улс төрийн ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Г.Ганбат, цэргийн сэтгүүлч, бэлтгэл хурандаа Г.Нямдорж нарын шинэ номын нээлтийг зохион байгуулж явуулсан.

➢ Үе үеийн төгсөгчдийг алдаршуулах зорилгоор Цэргийн Ерөнхий Дээд Сургууль, Цэргийн Нэгдсэн Дээд Сургуулийг Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалинтай, онц дүнтэй суралцаж төгссөн долоон төгсөгч мөн “Төрийн торгон цэрэг” хэмээх Хүндэт харуулын тусгай ротын болон салааны захирагчаар ажиллаж байсан таван офицерт хүндэтгэл үзүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Батлан хамгаалахын Төв архиваас лавлагааг нь гаргуулж батламжийг гардуулсан.

ЦЭРГИЙН УЛС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ОН ДАРААЛЛЫН ХУУДСАНД

Монгол Улсын орчин үеийн Зэвсэгт хүчний байгуулалтын хөгжлийн түүхэн явцад Цэргийн доторх улс төрийн байгууллага, ажилтны гүйцэтгэсэн үүрэг, үзүүлсэн үр нөлөө, түүхэн ач холбогдол, туршлага, сургаж үлэмж их.

Улс төрийн ажил бол Зэвсэгт хүчний үндсэн үүрэг, зорилгоо амжилттай хэрэгжүүлэх, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахууны тогтвортой байдлыг хангах, эх оронч үзлийг хүүхэд, залуус, цэргийн алба хаагчид, нийт иргэдэд төлөвшүүлэх нөр их ажлын салшгүй хэсэг, гол хүчин болсоор ирсэн ба өдгөө ч түүхэн ач холбогдол нь өндөр хэвээр байна.

Батлан хамгаалах салбарын түүхэн туршлага, хөгжлийн явцаас

харахад хаана улс төр, соёл хүмүүжлийн ажил сайн цэгцтэй, өндөр зохион байгуулалттай явагдаж байна, чухамдаа тэнд л хатуу чанд сахилга бат, ажлын хариуцлага, аливаа үүрэг хүлээх бэлэн байдал, шуурхай, чадварлаг үйл ажиллагаа, бие бүрэлдэхүүний бие бялдрын болон сэтгэл зүйн тогтвортой бэлтгэл, аливаа бэрхшээлийг даван туулах тэсвэр хатуужил төлөвшсөн байдаг.

Цэргийн доторх улс төрийн байгууллага, ажилтны олон талт үйл ажиллагаа нь байгуулагдсан цагаасаа нийгмийн хөгжил, хүмүүсийн оюун санааны хувьсал, шинэчлэлтийг дагаж агуулга, хэлбэр, бүтэц, зохион байгуулалтын хувьд ихээхэн өөрчлөгдсөөр ирсэн юм.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

- 1921 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс Цэргийн яамны Улс төрийн хэлтэс буюу Сурган боловсруулах хэлтэс;
- 1924 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс Цэрэг, ардыг Сурган боловсруулах газар;
- 1934 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс Улаан цэргийн Улс төрийн ба Сурган боловсруулах газар;
- 1936 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс Ардын хувьсгалт цэргийн Улс төрийн газар;
- 1937-1945 онд Бүх цэргийн Улс төрийн газар;
- 1971-1990 онд Монголын Ардын

- Армийн Улс төрийн газар;
- 1990-1992 онд Улс төр, хүмүүжлийн газар;
- 1992-1997 онд Зэвсэгт хүчний Ерөнхий штабын Сургалт, соёл хүмүүжлийн газар;
- 1992-2010 онд ЗХЖШ-ын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтэс, Цэргийн алба, соёл хүмүүжлийн хэлтэс;
- 2010-2017 онд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс;
- 2017 оны 1 дүгээр сараас ЗХЖШ-ын Иргэн-цэргийн харилцааны хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаагаа амжилт дүүрэн хэрэгжүүлж байна.



100 ЖИЛИЙН ОЙГ УГТАЖ ...

❖ Монгол цэргийн музейд шинээр байгуулсан “Цэргийн улс төрийн байгууллагын түүхэн замналыг харуулсан үзүүлэлийн танхим”-ыг эд өлгийн зүйлээр баяжуулах, цаашид зарим үзүүлэлийг цахим хэлбэрт шилжүүлэх;

❖ “Цэргийн доторх улс төрийн байгууллагын түүхийн тойм”, “1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад улс төрийн ажилтнуудын дургтгал болон Ахмад улс төрийн ажилтнуудын дурсамж, дургтгалын номыг бүтээх;

❖ “Цэргийн улс төрийн байгууллагын түүхэн замнал” баримтат киног бүтээх;

❖ “Цэргийн улс төрийн байгууллагын түүхэн замнал” сэдэвт гэрэл зургийн цомог гаргах;

❖ “Цэргийн улс төрийн байгууллага-100 жил” дурсгалын медаль, энгэрийн тэмдэг хийлгэх зэрэг ажлуудыг төлөвлөсөн ба хэрэгжилтийг нь хангах ажлыг эхлүүлээд байна.

САНААЧЛАН ХЭВЛҮҮЛСЭН НОМУУД

❖ Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн Аюулгүй байдлын сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн тэнхимийн 50 жилийн ойд зориулж, үе үеийн төгсөгчдийн дэмжлэгтэйгээр “Ардын цэргийн нийгэм-улс төрийн амьдралын халуун голомт” түүх, дурсамжийн номыг 2017 онд;

❖ Цэргийн доторх улс төрийн байгууллагын 100 жилийн ойг угтсан ажлын хүрээнд доктор, дэд хурандаа Лхамсүрэнгийн Баяр

“Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Цэрэг, ардыг сурган боловсруулах газрын түүхийн товчоо 1921-1934 он” номыг 2018 онд;

❖ Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ой, Чөлөөлөх дайны 75 жилийн ойд зориулан чөлөөнд байгаа хурандаа Г.Ганбат, бэлтгэл хурандаа Б.Жуваа, хурандаа Б.Отгонбаяр нарын эмхэтгэсэн “Дуунд мөнхөрсөн баатрууд” шүлэг, дууны эмхэтгэл номыг 2019 онд тус тус хэвлүүлсэн.

ХАТАН ЗОРИГТ ГЭЛЭГБААТАР



Аюулт дайны үхлийн галыг Алтан амиараа хаасан Эрэмгий дайчдаа зоригжуулж явсан Их буучин, улс төрийн удирдагч аа Хөвч, тайгын цэнхэр хангай Хөвсгөл нутгийн золбоотой хүү Халхын голын дайны гарамгай дайчин Хатан зоригт Гэлэгбаатар аа Алдар гавьяагаа мандаан бадруулсан Армийн их буучдын ариун жагсаалд Эрэлхэг Гэлэгбаатарын гавьяа нь Эгнэгт мөнхөд алдаршсан юм Дахилт

Д.Цэнд-Аюуш: ХАЙРЛАХ УЧИРТАЙ БҮХНИЙТ МИНЬ...

Энэ удаагийн “Залуус” булангийн зочноор БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй IX ээлжийн Мотобуудлагын батальоны БХР-ын Холбооны салааны холбоочин, дэд ахлагч Д.Цэнд-Аюуш (Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн холбооны засварын техникч, ахлах ахлагч) уригдлаа. Түүнийг радио спортын Олон улсын хэмжээний мастер гэдгийг уншигч та бүхэн тэр бүр сайн мэдэхгүй байж болох юм. Эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжилдээ эзэн байх тэр эрхэм чанарыг хадгалж яваа холбоочин бүсгүйтэй хөөрөлдөж суухдаа өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрж байв. Ингээд олон зүйлийг эс нуршин түүний ярианд уншигч та бүхний анхаарлыг хандуулъя.

Таны төрж өссөн нутаг, төгссөн сургуулийн талаар ярилцлагаа эхэлье ...

-Би Завхан аймгийн Алдархаан сумын уугуул, хоёр эрэгтэй, нэг эмэгтэй дүү дагуулсан эгэл айлын ууган охин. Бид эгэл ажилчны гэр бүлд төрж өссөн. Тодруулбал, аав маань малын эмч, ээж зоотехникч мэргэжилтэй, насаараа эл мэргэжлээрээ хөдөлмөрлөсөн хүмүүс. Аавын хувьд малын эмчийн зэрэгцээ бригадын даргын албыг олон жил хашсан. Одоо тэд маань гавьяаныхаа амралтыг эдлээд үр хүүхдүүд, ач, ээ нартайгаа бужигнаад энх тунх суугаа. Миний хувьд 1996 онд Завхан аймгийн Улиастай хотын 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 2002 онд МУИС-ийг эдийн засагч, нягтлан бодогч мэргэжлээр, нэлээд хожуу буюу энд ирэхийнхээ өмнө ХУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийг англи хэлний багш, орчуулагч мэргэжлээр дүүргэсэн.

Зэвсэгт хүчинтэй ямар хувь тохиолоор холбогдсон бэ?

-Үнэхээр л бурхны зурсан зураг, төөргөөр энэ салбартай холбогдсон гэж би боддог юм. Намайг их сургуулийн 2 дугаар курст орсон жил эмэгтэй дүү маань нэгдүгээр ангид элслээ. Хоёр эрэгтэй дүүгийн маань нэг нь цэргийн албанд, нөгөө нь мөн оюутан болоод явчихсан. Аав, ээж хоёр тун завгүй ажилтай, дүүг маань аймгийн төвд харах хүн байхгүй болж таарав. Тэгээд л би дүүгээ харахаар тохон томилогдож сургуулиасаа жилийн чөлөө авснаар Зэвсэгт хүчинтэй холбогдох үүд хаалга нээгдсэн дээ. Тухайн үед ээжийн маань нэг дүү Зэвсэгт хүчний 325 дугаар ангид ажилладаг байлаа. Тэр хүний зааж зөвлөснөөр 1999 оны 3 дугаар сард тус ангид ажилд орсон. Намайг очсоны маргааш нь тус ангид радио телеграфчин, операторчин бэлтгэх дамжаа ч хичээллэж таарлаа. Түүнд элсэх боломж ч олгогдсон. Дамжаагаа радио спортын хоёрдугаар зэрэгтэй төгсөж тус ангийн үндсэн ажилтан төдийгүй мөрдэс гоёсон цэргийн хүн болсон доо. Ажил, амьдралынхаа гарааг эхэлсэн энэ ангидаа 1999-2010 онд ХАРТ-д тасгийн захирагч, ээлжийн даргаар ажиллаж байгаад Зэвсэгт хүчний 330 дугаар ангид шилжин алба хааж байна.

Их сургуулийн оюутан охин түр хугацаанд ажиллана гэсэн бодолтой цэргийн ангийн босгоор алхсан байх гэж бодож байна. Гэтэл эсрэгээрээ бүр “Цэргийн хүн” болчихсон байдаг. Эргэлт буцалтгүйгээр ийм шийдвэр гаргах шалтгаан нь юу байв?

-Яг тийм, үнэхээр түр зуур ажиллана гэсэн бодолтой очсон. Гэвч хоёрдугаар курсийн жаахан охинд цэргийн ангийн бүхий л зүйл сонин содон, шинэ соргог, өвөрмөц, сонирхолтой санагддаг байлаа. Товчхондоо шал өөр ертөнц угтсан гэх үү дээ. Ялангуяа радио телеграфчин мэргэжилдээ чин сэтгэлээсээ дурласан. Тийм ч учраас түүндээ бүхий л сэтгэлээ зориулж, амархан суралцаж, дадлагажин хамт олондоо уусаж, тэднийхээ нэгээхэн эд эс нь болсон юм. Ажилтай болчихлоо гээд их сургуулиасаа нүүр буруулаагүй, цаг гаргаж төгссөн. Тухайн үеийн ангийн удирдлагууд маань ч намайг дэмжиж тэрхүү боломжийг бүрдүүлсэнд үнэхээр талархдаг. Хэдийгээр эдийн засагч мэргэжлээрээ ажиллаагүй ч сурсан, мэдсэн зүйл хүнд хэзээ ч илүүдэхгүй шүү дээ.

Цэргийн анги, байгууллага гэдэг бол тэсвэр хатуужлын томоохон талбар гэж ойлгодог. Танд энэ талбараас няцаж ухрах үе тохиолдож байв уу?

-Одоо бодоход шантарч

няцах уу, зорилгоосоо ухрах уу эсвэл урагшлах уу гэдэг чинь ердөө л хувь хүний хандлагаас хамаардаг юм байна. Дээр нь анхны сэтгэгдэл, ойлголт ч нөлөөлдөг бололтой. Миний хувьд урьд нь өөр ямар нэгэн газар ажиллаж үзээгүй, дөнгөж ажлын зах зухаас атгаж байгаа хорь ч хүрээгүй хүүхэд байсан болохоор эхнээсээ цэргийн ангийн дэг жаяг, дүрэм, журам, ажлын ачаалал, хээрийн гаралт гээд бүхий л зүйлийг ийм л байх ёстой юм байна гээд хүлээж аваад уураг тархиндаа суулгачихсан болохоор хэзээ ч шантарч, няцаж байгаагүй. Тийм эрх ч байхгүй.

Радио спортын төрлөөр улсын болоод тив, дэлхийн чанартай олон тэмцээнд зодоглон чамлахааргүй амжилтуудын эзэн болж, эх орныхоо нэрийг дэлхийн чихнээ дуурьсгасан удаа танд цөөнгүй бий юм билээ. Энэ талаар яриагаа үргэлжлүүлье ...

-Холбоочин хэмээх энгийн атлаа эрхэм бас тэгээд тийм ч хялбар биш мэргэжлийг би санамсаргүй бөгөөд азтай хувь тохиолоор эзэмшсэн. Түүндээ дурласаар л, суралцаар л яваа. Холбоочин гэх тодотголын эзэн болсноос хойш цөөнгүй

Одоо бодоход шантарч няцах уу, зорилгоосоо ухрах уу эсвэл урагшлах уу гэдэг чинь ердөө л хувь хүний хандлагаас хамаардаг юм байна. Дээр нь анхны сэтгэгдэл, ойлголт ч нөлөөлдөг бололтой. Миний хувьд урьд нь өөр ямар нэгэн газар ажиллаж үзээгүй, дөнгөж ажлын зах зухаас атгаж байгаа хорь ч хүрээгүй хүүхэд байсан болохоор эхнээсээ цэргийн ангийн дэг жаяг, дүрэм, журам, ажлын ачаалал, хээрийн гаралт гээд бүхий л зүйлийг ийм л байх ёстой юм байна гээд хүлээж аваад уураг тархиндаа суулгачихсан болохоор хэзээ ч шантарч, няцаж байгаагүй. Тийм эрх ч байхгүй.

тэмцээнд оролцож байна. Улсын чанартай уламжлалт тэмцээн болох хошууч генерал Р.Гаваа, Ж.Гуррагчаа нарын нэрэмжит хурдач радист, холбоочдын цогцолбор тэмцээн мөн радио долгионы чиглэл олох радио пеленгацын тэмцээнд жил бүр амжилттай оролцдог. Эдгээр тэмцээнийхээ амжилтаар 2003 онд нэгдүгээр зэрэг, 2006 онд дэд мастер, 2008 онд спортын мастерын болзуудыг тус тус хангасан.

Олон улсын чанартай тэмцээний гараа маань 2009 оноос эхлэлтэй. Тухайн онд Болгар улсын нийслэл Софи хотноо болсон Дэлхийн аварга шалгаруулах өндөр хурдны радио телеграфчин, операторчны тэмцээнд медальт дөрөвдүгээр байрт шалгарч

радио спортын төрөлд ОУХМ-ын болзлыг хангасан. Энэхүү амжилт маань Монгол Улсын радио спортын түүхэнд анхдагч болсон юм.

Швейцарийн Женев хотноо 2012 онд болсон ДАШТ-д мөн дээрх төрлөөр оролцож багаараа V, хувийн амжилтаар VI байрт шалгарсан. 2013 онд БНСУ-ын нийслэл Сөүл хотноо болсон Ази тивийн аварга шалгаруулах ес дэх удаагийн тэмцээнд радио долгионы чиглэл олох төрлөөр оролцож аваргын алтан медаль хүртсэний дээр энэ төрлөөрөө буюу хоёр дахь төрлөөр мөн ОУХМ-ын болзол хангасан. Мөн 2016 онд манай улсад болсон Ази тивийн аварга шалгаруулах 10 дахь удаагийн тэмцээнээс хос алт, хос мөнгөн медаль хүртэж, Ази тивийн аваргын хошой алтан медалийн эзэн болсон доо.

Дэлхийн чанартай анхны тэмцээнийхээ шагналт байрт шалгарч, ОУХМ-ын болзол хангачаад шагналын тавцанд зогсож байсан тэр агшнаа эргээд нэг дурсахгүй юу? Таны сэтгэлд тодоос тод дурсамжийг үлдээсэн нь лавтай ...

-Үнэхээр тодоос тод хөгтэй дурсамж үлдээсэн (инээв). Энэ тухай ярих хэрэг байна уу, ёстой ичмээр санагдаж байна шүү.

Ярь л даа, хөгтэй дурсамжаасаа бусадтай хуваалцах юу нь буруу гэж ...

-Яг үнэндээ би тийм сүрхий амжилт үзүүлснээ огт мэдээгүй явсаар эх орондоо ирсэн юм. Хэл мэдэхгүйн балаг л тэр шүү дээ. Тэмцээн дууссаны дараа тэмцээнийг зохион байгуулсан, шүүсэн зэрэг бараг бүх хүн намайг зорьж ирэн баяр хүргэж, барьж авч үнсээд л байлаа. Би ямар урьд нь гадаад улсад явж үнсэн биш, жинхэнэ хөдөөний хүн л байна биз дээ. Тиймдээ ч нөгөө соёл, эелдэг боловсон харилцаа гээч нь энэ байх гэсэн шүү юм бодоод ер тоосонгүй өнгөрлөө. Дараа нь багаараа Хар далайн эрэг дээр элсээр тоглоод далайн гайхамшигийг хараад байж байтал нэг хүн ирээд орой 18 цагаас хүлээн авалтад оролцох ёстойг хэлэх шиг боллоо. Бид ч хагас дутуу ойлгоод хүлээн авалтдаа жаахан хоцроод очсон. Тэгсэн биднийг сүртэй нь аргагүй угтаж аваад намайг улаан хивсэн дээгүүр хөтөлж явсаар тайзан дээр гаргав. Тэгснээ энгэрт нэг медаль зүүлээ, өргөмжлөл шиг хоёр, гурван ногоон цаас, бас нэг хээ хуар болсон том цагаан дугтуй өглөө. Би ч тэмцээнд оролцсон хүн бүрд ийм дурсамж өгч байгаа юм байна л гэж бодлоо. За ингээд л хүлээн авалт дууслаа. Хэдэн өдөр газар үзэж, гадуур сайхан зугаалчаад эх орондоо ч ирлээ. Тэгсэн онгоцны буудал дээр Радио спортын төв клубийн тэргүүн маань нарийн бичгийн дарга, зарим удирдлагын хамтаар үлээвэр найрал хөгжимтэй их л сүртэй угтлаа. Тэд бүгдээрээ баяр хүргэж үнсээд л, сүйд боллоо. Бас болоогүй ээ, сэтгүүлчид ирчихсэн ярилцлага авлаа, би гэдэг хүн юу ч ярьсан юм. Ямар амжилт үзүүлснээ ч мэдээгүй, олон улсын чанартай тэмцээнд оролцоод ирэхээр л ингэдэг юм байна гэж ойлгож байсан хүн яавч олигтой юм яриагүй нь лавтай /инээв/. Гэтэл клубийн нарийн бичгийн дарга маань намайг шагналт IV байрт шалгарч, ОУХМ-ын болзол хангасан, энэ нь Монголын радио спортын түүхэнд анхдагч гээд л ярьж байна. Би ч сонсоод "шок"-д орлоо. Айх, гайхах, баярлах, амжилтаа ч мэдээгүй явснаасаа санаа зовох, ичих зэрэгцээд юм юм л болж билээ.

Нөгөө тоохгүй байсан ногоон цааснууд, энгэрийн тэмдэг, дугтуйтай зүйлс л амжилтыг тань гэрчлээд байж дээ ...

-Хэлээд юу гэх вэ. Одоо



эргээд санахад тэнэг хүн ч ойлгохоор дөрөвдүгээр байр гээд бичихсэн сертификат, ОУХМ-ын гэрчилгээ, медаль, шагналын дугтуйтай мөнгө зэрэг байж. Яах вэ хэнэггүй, хайхрамжгүй ч гэдэг юм уу, эсвэл нэг их юм тоодоггүй хүний л алдаа байхгүй юу.

Алдаа гэхээсээ илүү анхны тэмцээн байсан учраас бүхий л талаар туршлага дутсан байх л даа ...

-Тийм тал бий. Анх удаа хилийн дээс алхаж, олон улсын чанартай том тэмцээнд оролцсон болохоор ер нь тал бүрийн туршлага, мэдлэг, ойлголт дутмаг байсан. Гэхдээ дараа дараагийн тэмцээнд амжилтаа ахиулахаас эхлээд бүх талын туршлагыг хуримтлуулан бас нүд нээгдсэн.

Анхны тэмцээний амжилтаас асар их урам авч, дараа дараагийн амжилтын буухиа үргэлжилсэн нь гарцаагүй ...

-Тэгэлгүй яах вэ. Олон улсын чанартай анхныхаа тэмцээний амжилтаар ОУХМ-ын болзлыг хангасны дээр Монголын радио спортын түүхэнд бас нэг тод мөр үлдээсэндээ баярлаж, ийм амжилт үзүүлэх бүх талын нөхцөл боломжийг бүрдүүлсэн, анхны алхмыг минь зөв эхлүүлсэн хүмүүст талархдаг юм. Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн босгоор дөнгөж алхаж ороход дэмжиж, дамжаанд хамруулан гарыг минь ганзага, хөлийг минь дөрөөнд хүрэхэд хэмжээлшгүй хувь нэмэр оруулсан хурандаа Ш.Энхбат, Н.Энхбат, Дашжаргал, В.Лувсанпүрэв, Т.Ганбат, Д.Энхбор, хошууч Зоригт гээд олон даргаа энд дурдаж талархал илэрхийлье. Түүнчлэн хожим 330 дугаар ангид шилжин ирэхэд ангийн захирагч, хурандаа С.Дашзэвэг, Б.Баатар болон дэд хурандаа Н.Бат-Эрдэнэ, С.Ууганбаяр, Т.Буянбат гээд ангийн удирдлагууд маань дэмжиж, туслан дараа дараагийн тэмцээнд амжилт үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлдэг байсан. Тиймээс дарга нартаа их баярладаг юм. Мөн хань маань мэргэжил нэгтэй учраас намайг маш сайн ойлгож, дэмждэг.

Мэргэжил бүхэн сайхан гэдэг. Та мэргэжлийнхээ

сайхныг товч тодорхойлбол ...

-Тийм ээ, мэргэжил бүхэн сайхан. Тэр дундаас миний мэргэжил хамгийн сайхан. Товчхондоо холбоочид бид чинь холыг ойртуулж, хоёрыг уулзуулдаг хүмүүс шүү дээ. Ер нь харилцаа, холбоогүйгээр аливааг төсөөлөх аргагүй.

Хэн нэгний амжилтын ард гэр бүлийн гишүүдийн асар их оролцоо, хувь нэмэр оршдог. Таны амжилтын ард байдаг гэр бүлийнхнээ танилцуулахгүй юу?

-Ханийг маань Д.Ганбат гэдэг. Мөн л Завхан нутгийн хүн. Зэвсэгт хүчний 330 дугаар ангид тасгийн захирагч-станцын дарга, ахлах ахлагч цолтой. Бас “холбооны хүн”. Бид хоёр хүүхэдтэй. Охин 12, хүү 6 дугаар ангийн сурагчид. Охин маань гар бөмбөг, хүү цанын спортоор хичээллэдэг, хоёулаа нэгдүгээр зэрэгтэй. Миний хувьд хүүхдүүдээ цэргийн бас спортын хүн болгохгүй гэсэн далдын хүсэл байсан ч тэдний сонирхлыг нь хүндэтгэсэн. Би өөрийгөө их азтайд тооцдог юм. Яагаад гэвэл амьдралынхаа туршид хайрлах учиртай бүхнийг минь Зэвсэгт хүчин надад өгсөн. Тодруулбал, насны хань, насаараа ажиллах мэргэжил, үе, үеийн удирдлага, хамт олон, найз нөхөд гээд амьдралд минь өнгө чимэг, хөг аялгуу нэмсэн бүхнийг надад өгсөн болохоор сэтгэл хангалуун амьдардаг.

Таны бахархал юу вэ?

-Миний аав, ээж. Үр хүүхдүүдээ эрүүл саруул, элэг бүтэн төрүүлж өсгөн өдий зэрэгт хүргэсэн ижий, ааваараа бахархахгүй хэн байх билээ. Аав, ээж минь биднийг хэнийг ч ялгалгүй харьцаж олонтойгоо байхад, үнэн цагаан хөдөлмөрийнхөө үр шимээр амьдрахад сургасан.

Сүүлийн асуултыг танд үлдээе ...

-Юуны өмнө хүний нутагт мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэж байгаа хамт олондоо, тэднийхээ ар гэрийнхэнд нь ажлын амжилт, хамгийн сайн сайхныг хүсье. Түүнчлэн хүн ямар нэгэн зорилготой байж, түүнийхээ төлөө туштай хөдөлмөрлөхөд амжилт бүхэн ойрхон байдаг гэдгийг онцолье.

Ярилцсанд баярлалаа.

Ахмад Д.МЭНДБАЯР

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон мото механикжуулсан 7 дугаар хуягт бригадын 1 дүгээр батальоны 1 дүгээр ротын улс төрийн орлогч, ахлагч Б.Шүхэрт 1916 онд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт мэндэлсэн. Тэрээр 1939-1945 онд цэргийн алба хааж, 1945 оны Чөлөөлөх дайнд байлдааны үүргээ онц гарамгай биелүүлсэн ба 1946 онд цэргийн албанаас халагджээ. Түүний гавьяа, зүтгэл, хөдөлмөр, бүтээлийг төр, засгаас өндөрөөр үнэлэн 1945 оны Чөлөөлөх дайнд байлдааны үүргээ онц гарамгай биелүүлсний учир Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Монгол, Зөвлөлтийн "Бид ялав", Ардын хувьсгал, Ардын Арми, Халхын голын байлдааны болон Чөлөөлөх дайны ялалтын ойн медалиудаар шагнасан бөгөөд ЗХУ-ын Улаан тугийн одон хүртээжээ. Мөн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, МХЗЭ-ийн Төв хорооны "Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч" цол, тэмдгээр шагнасан нь түүний ажил, амжилтыг нь илэрхийлсэн баталгаа мөнөөс мөн бөлгөө.

Энд онцлоход, 1995 онд Чөлөөлөх дайны ялалтын 50 жилийн ойг тохиолдуулан Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, ахмад дайчин Б.Шүхэртэд "Монгол Улсын баатар" цол олгуулахаар Дорноговь аймгийн ахмад дайчид, иргэд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Ухнаа, Засаг дарга Л.Одончимэд нарын гарын үсэгтэй тодорхойлолт болон хүсэлтийг төр, засгийн дээд байгууллагад уламжилсны эцэст Сүхбаатарын одонгоор шагнажээ.

Б.Шүхэрт 1939-1944 онд БНМАУ-ын баатар, хурандаа Ш.Гонгорын командалсан Хуягт бригад таван жил байлдагч, бага даргаар алба хааж, 1944 онд цэргийн албанаас халагджээ. Түүнийг 1945 онд Дорноговь аймгийн клубийн даргаар ажиллаж байхад нь дайны үеийн цагийн байдлаас шалтгаалан түр цэрэгт татсанаар хуучин цэргийн алба хааж байсан хуягт бригаддаа ирсэн юм. Тэр бээр 1945 оны Чөлөөлөх дайнд хурандаа Д.Нянтайсүрэнгийн командалсан МАХЦ-ийн 7 дугаар хуягт бригад, Зөвлөлт-Монголын цэргийн морьт механикжуулсан бүлгийн бүрэлдэхүүнд багтан Чуулалт хаалга, Жанчхүүгийн давааны чиглэлд байлдааны ажиллагаанд оролцсон юм. Дорноговь аймгийн Сайншанд хотод байрлаж байсан мото механикжуулсан 7 дугаар хуягт бригад 1945 оны 7 дугаар сарын сүүлчээр Цэргийн дээд командлалын шийдвэрээр түгшүүрийн дохиогоор хөдлөн Замын-Үүд сумын нутаг, Зүүн өмнөд зүгт БНМАУ-ын хилийг давж, Өвөр Монголын нутаг

хятад иргэнийг дайчлан ажиллуулж Жанчхүүгийн даваанд 35 км өргөн, 10 км гүн бэхэлсэн хориглолтын "цайзыг" байгуулж, түүндээ тулгуурт байр 20 гаруй, их буу, пулемётын галын цэг 36-г далд байрлуулсан ба "давагдашгүй цайз" хэмээн нэрлэж байсан юм. Энэхүү томоохон "бэхлэлт цайз"-ыг сэтлэх, эзлэх, устгах байлдааны онцгой үүрэг Зөвлөлтийн Армийн 27 дугаар мотобуудлагын бригад, МАХЦ-ийн 7 дугаар хуягт бригаддаа оногджээ. Энэ үед Зөвлөлт-Монголын морьт механикжуулсан бүлгийн командлагч, генерал И.А.Плиевийн шийдвэрээр 1945 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн үүрээр их буу, нисэх онгоцоор галын хүчтэй бэлтгэл хийсний дараа Зөвлөлт- Монголын дайчид давшилтад оржээ. Жанчхүүгийн даваанд



Ахмад дайчин Б.ШҮХЭРТ

хамт мөлхөн явахдаа дайсны хэд хэдэн галын цэгийг устгаж, дайсны танкийн саад, дэлбэрсэн гүүрийг даван туулж, хоёр нөхрөө уйгагүй эрсний үр дүнд хүндээр шархадсан Г.Дашдондоого олж, түүний шархыг боожээ. Харин цааш мөлхөж байтал буу барьсан япон Шүхэрт рүү дөхөж байсныг урьтан харж буудан унагажээ. Г.Дашдондоогоос цааш 50 метрийн зайд зоригт пулемётчин Л.Аюуш дайсны 7-8 хүнийг устгаад өөрөө амиа алдсаныг нь олж ангийн удирдлагад мэдээлжээ. Улмаар 8 дугаар сарын 20-ны өдөр батальоны удирдлагаас ахлагч Б.Шүхэртэд байлдааны тэргүүн

явахдаа Л.Аюуш, Г.Дашдондог, С.Дампил, Д.Данзанваанчиг зэрэг дайчин нөхдийн жишээгээр улам эрэмгий зоригтой сайн байлдаарай гээд өөрөө дайны талбараас буцаж байгаадаа гүн харамсаж байсан билээ" гэжээ. (Д.Сэдэд "Сайншандаас-Жанчхүүгийн даваа хүртэл" ном. 2015 он, 144 дүгээр хуудас)

МАХЦ-ийн мото механикжуулсан 7 дугаар хуягт бригадын 2 дугаар батальоны захирагч, хошууч Л.Сосор, улс төрийн орлогч, хошууч, Л.Түвдэнгийн дурсамжид "Салбарын улс төрийн орлогч, ахлагч Б.Шүхэрт байлдааны цагийн хамгийн хүнд хэсэгт байлдааны үүрэг, даалгаврыг эр зориг, авхаалж самбаа гарган биелүүлж, баатарлаг гавьяа байгуулсан ба олон удаа шархдаж, үхэлтэй тэмцэлдэн амьд үлдсэн юм шүү. Б.Шүхэрт салаа, салбарын хэмжээнд ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, цэрэг, дайчдыг зоригжуулах

БААТРЫН ЭНТЭЙ ТУЛАЛДСАН УЛС ТӨРИЙН ОРЛОГЧ

Японы цэргийг бут цохих, бэхлэлт цайзыг сэтлэх, устгах ширүүн тулалдаанд хурандаа Д.Нянтайсүрэнгийн командалсан МАХЦ-ийн 7 дугаар мото механикжуулсан хуягт бригадын хошууч Л.Сосорын удирдсан анги, салбар тулалдааны тэргүүн шугамд явж, эрэлхэг, баатарлаг, эр зоригийн үлгэр жишээг үзүүлсэн юм. Тус анги, салбараас эх орныхоо төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, алтан амь, асгарха цусаа үл хайрлан тулалдсан БНМАУ-ын баатар С.Дампил, Д.Данзанваанчиг, М.Жанчив, Л.Аюуш, Т.Дүүдэй нарын эрэлхэг гавьяаг бид сайн мэдэх билээ.

Энэхүү нийтлэлд 7 дугаар хуягт бригадын хошууч Л.Сосор даргатай, хошууч Л.Түвдэн улс төрийн орлогчтой батальоны салбарын улс төрийн орлогч, ахлагч Баламын Шүхэрт байлдааны үүргээ хэрхэн гүйцэтгэсэн, байлдааны тэргүүн шугамд тулалдаж байсан цэрэг, дайчидтайгаа хэрхэн ажиллаж, тэднийгээ зоригжуулж, ямар арга, хэлбэрээр улс төр, хүмүүжлийн болон ухуулга, таниулгын ажлуудыг зохион явуулж байсан тухай тодруулахыг зориллоо. Б.Шүхэрт салбарын улс төрийн орлогчийн хувьд цэрэг, дайчдын дунд өргөсөн тангарагтаа үнэнч байж, төр, засаг,

дайны цагт байлдааны үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг, дайчдад дайны зорилго, байлдааны цагийн байдлыг шуурхай хүргэхэд онцгой анхаарч, тэднийг зоригжуулан зохион байгуулахад онцгой анхааран ажиллаж байв. Тэрээр маршийн үед тагнуулын үүрэг гүйцэтгэх, давших байлдаанд тэргүүн эгнээнд томилогдсон анги, салбарын бүрэлдэхүүнийг тусад нь хүлээн авч уулзах, заавар, зөвлөгөө өгөх, нам, эвлэлийн хэсэг байгуулах, тэргүүний дайчдыг нам, эвлэлийн гишүүнд элсүүлэх ажлуудыг зохион байгуулж байв. Б.Шүхэрт байлдааны нөхцөлд ухуулга, сурталчилгааны ажлыг шуудуу, нуувчийг дамжин хийж байлдааны явц, өөрийн цэргийн баатарлаг, гавьяат үйлс, ялалтын талаар шуурхай мэдээлж, дайчин хуудас, цахилгаан сонин, ухуулах хуудсыг тараах, дамжуулах зэрэг ухуулга, сурталчилгааны шуурхай хэлбэрүүдийг ашиглан байлдаж байгаа салбар, салааны цэрэг, түрүүч, дарга нарт хүргэх ажлуудыг тасралтгүй зохион байгуулж байсан нь ахмад дайчдын дурсамжид бий. Б.Шүхэрт Жанчхүүгийн давааны тулалдаан эхлэхийн өмнө өөрийн удирдсан салбараас 20 гаруй шилдэг, тэргүүний дайчдыг нам, эвлэлийн гишүүнээр элсүүлжээ. Тэрхүү ширүүн тулалдааны

шугамд үүрэг гүйцэтгэж байгаа ахлагч Т.Дүүдэйн салаанд очих үүрэг өгсөн ба байлдааны ажиллагаа улам бүр ширүүсэж, буун дуу нижигнэн, их бууны сум, мина энд тэндгүй, эргэн тойрон дэлбэрч, сум шунгинаж байлаа. Энэ үед бага дэслэгч Д.Санжийн удирдсан их бууны салаан дээр очсон ба нуувч бүрээр орж цэргүүдтэй уулзан эх орныхоо төлөө баатарлагаар тулалдсан зоригт пулемётчин Л.Аюуш, Г.Дашдондог нарын эр зориг, баатарлаг үйлсийн тухай ярьж, тэднийг ялалтад зоригжуулж байлаа. Энэ үед баруун талд нь ойрхон буун дуу гарч араас нь хүнд юмаар цохиод авах шиг болов. Энэ бол аливаа нэг зүйлээр цохих биш сум оносон гэдгийг Шүхэрт ойлгожээ. Дайсны хараалсан газраас зайлах хэрэгтэйг мэдэж, хажуу талаараа өнхөрч хөвтэв. Гэтэл дайсны хоёр дахь сум автомат барьсан гарынх нь алгьсэт цохин, дараах сум нь сувгээ өөд нь халуун оргуулав. Шүхэрт огт хөдөлгөөнгүй хэсэг хэвтжээ. Түүнийг хөдөлгөөнгүй болсон учраас япон цэрэг цээжээ нуувчнаас цухуйлган өндийн харлаа. Энэхэн зуур Шүхэрт өндийн дайсан руу бүтэн дийстай сумаа илгээж дайсныг устгасан ажээ. Байлдааны талбарт гурван удаагийн сумны шарх авсан Шүхэрт их цус алдан ухаан балартаж байхад дайчин нөхөд нь ар тал руу илгээснээр эмнэлэгт хүргэн амь насыг нь аварчээ.

"Эх оронч" Б.Шүхэртийн тухай Жанчхүүгийн даваанд болсон ширүүн тулалдаанд мото механикжуулсан 7 дугаар хуягт бригаддаа хамт алба хааж, мөр зэрэгцэн тулалдаж явсан ахмад дайчдын зарим дурсамжаас та бүхний сонорт хүргэж байна. Тодруулбал, БНМАУ-ын баатар, салааны захирагч, ахлагч Т.Дүүдэй "... Салбарын улс төрийн орлогч, ахлагч Б.Шүхэрт байлдааны галын шугамын тэргүүн эгнээнд байлдаж байгаа цэрэг, дайчидтай хамт байж, дайсны этгээд Монгол-Зөвлөлтийн дайчдын хамтарсан давшилтын хүчинд шахагдан асар их хохирол амсаж байгаа тухай мөн ах дүү хоёр армийн дайчдын ялалт, өөрийн ангийн байлдааны ажиллагааны амжилтууд, пулемётчинбайлдагч Л.Аюуш, түрүүч С.Дампил, байлдагч Д.Данзанваанчиг, Л.Төмөртөгоо нарын дайчид онц гарамгай мэргэн буудаж, дайсны олон галын цэг, амьд хүчийг устган салаа, салбарынхаа давшилтыг галаар ханган баатарлаг гавьяа байгуулсныг ухуулан танилцуулж, тэднийг ялалтад зоригжуулж байсан юм. Манай улс төрийн орлогч маань дайны талбарын тэргүүн эгнээнд явж нуувчнаас нуувч дамжин хүн бүртэй уулзаж, яриа, таниулга хийж явахдаа дайсны суманд 2-3 удаа хүндээр шархдан эмнэлгийн газар

болон нам, эвлэлийн гишүүнд элсүүлэх ажлыг бусдаас илүү зохион байгуулж байсан учраас түүний удирдаж байсан салбар нь байлдааны хүнд даалгаврыг нэр төртэй биелүүлж Чөлөөлөх дайныг ялалтад хүргэхэд гол үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг юм" гэж бичжээ. (Цогбадрах "Чуулалт хаалгын сум" ном. 2015 он, 91 дүгээр хуудас)

Ийнхүү Б.Шүхэрт Чөлөөлөх дайнд салбарын улс төрийн орлогчийн албан тушаалд ахлагч цолтойгоор байлдааны үүрэг гүйцэтгэж, 1945 оны 8 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд болсон Жанчхүүгийн даваанд дахь томоохон "бэхлэлт цайз"-ыг эзлэх ширүүн тулалдаанд анги, салбарын дайчдынхаа хамтаар байлдааны тэргүүн эгнээнд явж, улс төрийн тэргүүн эгнээнд явж, улс төрийн ажилтны хувьд исгэрэх сум, тэсрэх бөмбөгийг сөрөн дайчдад биеэр үлгэрлэн уран яруу үгээрээ цэрэг эрсээ ялалтаас ялалтад зоригжуулан, нуувчнаас нуувч руу мөлхөн манай дайчдын ялалтын шуурхай мэдээ, Японы цэргийн ялагдал, хохирлын тухай үнэн бодит мэдээллүүдийг шуурхай хүргэж явсан бөгөөд түүхэнд мөнхөрсөн улс төрийн ажилтнуудын нэг юм.

Б.Шүхэрт дайны дараа цэргийн албанаас халагдаж, дайны үед олсон гурван удаагийн хүнд шархаа эмчлүүлэн эрүүл болсноор эх орныхоо энхийн бүтээн байгуулалтад идэвхтэй оролцож, оройгоор 7-10 дугаар ангид суралцаж төгссөний зэрэгцээ 48 насандаа Улаанбаатар хотын Анагаах ухааны дунд сургуулийг дүүргэжээ. Тэрээр Дорноговь аймгийн клубийн эрхлэгч, аймгийн Анагаах ухааны дунд сургуулийн багш, Сайншанд хотын 10 жилийн сургуулийн эмч, багш зэрэг албыг нэр төртэй хашиж арми болон улсад 50 гаруй жил ажиллаад гавьяаныхаа амралтад гарчээ.

Бид энэ онд 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг ёслол тэмдэглэнэ. Тиймээс 1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайн, 1944-1948 оны Баруун хилийн тулгаралт-байлдаанд ялалт байгуулахын төлөө, эх орныхоо тусгаар тогтнол, газар нутгийн халдашгүй, дархан байдлын төлөө цэл залуу насаа зориулан асгарха цус, алтан амиа ч хайрлалгүй тэмцсэн баатарлаг үйл хэргийг нь та бид мартаж учиргүй. Энэхүү дурсамж нийтлэлээр зөвхөн нэгэн эх орончийн түүхэн гавьяаг тодруулахыг зорьж, уншигч танд толилууллаа. Тийм л эр зоригтой олон арван захирагч, дарга, түрүүч, байлдагч нарын түүхэн гавьяаг өнөө үеийн цэргийн алба хаагчид, үүхэд, залуус сайтар судалж, эх орончдынхоо алдар гавьяаг мөнхлөх нь зүйтэй санагдана.

Бэлтгэл хурандаа Г.ГАНБАТ



Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Б.ШҮХЭРТ, ахмад дайчдын хамт Халхын голын баатруудын хөшөөнд хүндэтгэл үзүүлж байгаа нь

орсон юм. Монгол-Зөвлөлтийн дайчид Цагаан-Овоо, Завсар, Жанбей хотыг Японы эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлөн 8 дугаар сарын 19-ний өдөр Жанчхүүгийн даваанд тулж ирсэн аж. Жанчхүүгийн даваа бол Чуулалт хаалган хотын ойролцоо оршдог, Зүүн хойд Хятадын Японы цэргийн командлалын томоохон бэхлэлт "цайз" байсан юм. 1935-1940 онд таван жилийн турш 40 мянган

армийн командлалаас өгсөн байлдааны үүрэг, даалгаврыг оновчтой, шуурхай биелүүлэх, тэдэнд Чөлөөлөх дайнд ялалт байгуулахын утга учир, түүхэн ач холбогдлыг тайлбарлахаас гадна байлдааны цагийн байдалтай нягт уялдуулан нэгтгэл, ангиудын маршийн болон давших байлдааны үед зохиох нам, улс төр, ухуулга, сурталчилгааны ажлуудыг чадварлаг зохион байгуулж байжээ. Энд юуны өмнө

явцад дайсны хориглолтын гүнд нэвтэрч өөрийн анги, салбараасаа тасарч сураггүй болсон пулемётчин Л.Аюуш, түүний туслах Г.Дашдондог нарыг олох, тэднийг ямар байдалд орсныг нь мэдэж, мэдээлэх байлдааны үүргийг салбарын улс төрийн орлогч, ахлагч Б.Шүхэртэд тус батальоны дарга хошууч Л.Сосор, улс төрийн орлогч хошууч Л.Түвдэн нараас өгчээ. Б.Шүхэрт хоёр дайчны

Бидний нэг

ЗА НУТАГ БУЦЬЯ, ЭНЭ ЦЭРГИЙНХЭН Ч ДЭЭ...

Гол баатраа, би хувьдаа “Инээдэг Нараа” гэж нэрлэдэг. Магадгүй, уншигч та энэ хэний тухай болохыг төвөггүйхэн мэдэх биз. БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч Г.Нармандах нь 37 дахь жилдээ нягтлан бодогчоор ажиллаж байгаа нэгэн бөгөөд Зэвсэгт хүчинд үр бүтээлтэй алба хааж байгаа ажилтан албан хаагчдын нэгэн төлөөлөл юм. Үргэлж инээд цацруулж, бахдам сайхан энергийг ойр тойрныхондоо түгээж байдаг тэрээр “Манай хэлтэс чинь их л онцлогтой шүү дээ” гэж ирээд л хэлтсээ, хамт олноо магтсаар яриагаа эхэлсэн юм.

Уншигчдадаа өөрийгөө танилцуулахгүй юу?

-Намайг Г.Нармандах гэдэг. Говь-Алтай аймгийн Биндэр сумынх. 10 дугаар ангиа төгсөөд хотод ирж байлаа. Их сургуулиа төгсөөд Мах комбинатад нягтлан бодогчоор ажиллаж байхдаа нөхөртэйгөө анх танилцаад Өмнөговь аймаг руу хамт явж байсан. Тэнд байх хугацаандаа Өмнөговь аймгийн "нисэх"-д ажиллаж байгаад 1992 онд Улаанбаатар хотод ирсэн. Нөхөр маань нийслэлийн цэргийн ангид томилогдсон хэрэг. Тэр жилдээ төв нисэхэд мэргэжлээрээ ажиллаж байгаад Зэвсэгт хүчний 065 дугаар ангид ажиллахаар болсон. Ахлах нягтлан бодогчоор тус ангид ажиллаж байгаад одоогийн БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтэст нягтлан бодогчоор 23 дахь жилдээ ажиллаж байна.

Хэлтсийнхээ онцлогийн талаар ярихгүй юу?

-Мөрдөсгүй цэргийнхэн гэдэг тодотгол манай хэлтсийнхэнд яг тохирдог юм. Учир нь хэлтсийн дийлэнх бүрэлдэхүүн нь энгийн алба хаагчид байдаг. БХЯ, ЗХЖШ-ын хашаанд болж өнгөрдөг бүхий л үйл ажиллагаанд бэлтгэл ажлаас нь эхлээд оролцохоос гадна өнцөг булан бүрд нь хүрч ажилладаг

нь манай хэлтсийнхний онцлог гэж тодотгож болно. Дан ганц энэ хашаагаар хязгаарлахгүй энд тэнд зохион байгуулагддаг цэргийн сургалт бэлтгэлийн бүхий л арга хэмжээнд оролцдог хүмүүс шүү дээ. Одоо бас бидний ажил харьцангуй хөнгөвчлөгдөж байна.

Өмнө нь манай хэлтэс 2000 онд буюу О.Чулуунбаатар даргын үед туслах аж ахуйтай байлаа. Энэ үед хэлтсээрээ явж БХЯ, ЗХЖШ-ын ажилтан алба хаагчдын цайны газрын хүнсний хэрэгцээний мах болох 400-500 хонийг нядалж өвлийн идэш бэлтгэдэг байсан. Мөн хавар төмс, хүнсний ногоо тарина, намар нь хурааж авна. Хураасан төмс, хүнсний ногоогоо хатаах, ялгах ажилд мөн л дарга цэрэг, энгийн цэргийн ялгалгүй бүгд оролцдог. Мөн тэрхүү туслах аж ахуйтай байх үед манайх дөрөв, таван малчинтай байсан юм. Тэр үед УААХ-ийн дарга О.Чулуунбаатар, тухайн үеийн нягтлан бодогч нар өглөө бүр ажил эхлэхээс өмнө малчдаасаа сүү, таргаа авч ирдэг байсан. Энэ нь ажилтан алба хаагчдын тухайн өдрийн сүү, цагаан идээний хэрэгцээг бүрэн хангадаг байлаа. Энэ бүгд эргээд харахад хамт олныг ажилд сургахаас гадна нийтэч, хамт олонсог болгож өдөг юм билээ.

Олон ажлыг хамт олны хүчээр даван гардаг байжээ.

-Тэгэлгүй яах вэ. Манай хамт олон шаардлага гарсан тохиолдолд аливаа нэгдсэн үйл ажиллагаа, ажилд хамтдаа ханцуй шамлаад л ордог. Бусад үед өөр өөрсдийн хариуцсан ажилдаа эзэн болдог. Энд нэг дурсамж хуучлахад, 2000 оны үед байх. Тэр зун тус хэлтсийн дийлэнх бүрэлдэхүүн амарч байхад нь 12 орны зочид ирсэн гээд дуудагдан "Тэрэлж"-д очиж үйлчилгээний албанд дайчлагдаж байсан. Тэр үед гаднын зочид ч их ирдэг байж.

Таны хувьд ажилдаа баримталдаг гол зарчим юу вэ?

-Миний үндсэн ажил бол нягтлан бодогч. БХЯ, ЗХЖШ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар, ажилтан албан хаагчдын болон гадаад, дотоодын сургуульд суралцах сонсогчдын хувцасны хангалтыг нь хариуцаж ажилладаг. Мөн эм, ороох боох материал, бичиг хэрэг гээд олон төрлийн ажлыг хариуцдаг юм. Тэгэхээр миний ажилд төлөвлөгөө, дэс дараалал хамгаас чухал. Тиймээс өглөө эртлэн гэрээсээ гарахдаа л тухайн өдрийн ажлаа төлөвлөдөг. Төлөвлөсөн ажлаа ямар ч үед биелүүлэхийг л өөрийн жанжин шугам болгож ирсэн. Мөн бусдадаа үлгэр жишээч байхыг эрхэм болгодог. Энэ ч ёсоор залуустаа үсээ засуул, хувцсаа цэвэр, аятайхан өмс, хамт олны дунд биеэ зөв авч яв гээд зах зухаас нь хэлж ярих зүйл бишгүй л байдаг.

Гэр бүлээ танилцуулна уу?

-Миний ханийг М.Ганшир гэдэг. ҮБХИС, Зэвсэгт хүчний 167, 013, 310, 353, 238, 065 дугаар ангиудад алба хааж байгаад өдгөө гавьяаныхаа амралтыг эдлэн суугаа бэлтгэл хурандаа. Бид гурван хүүхэдтэй.

Амьдралд тохиох нандин, сайхан дурсамжаасаа хуваалцахгүй юу?

-1986 оны 10 дугаар сарын 12-ны өдөр бид Улаанбаатар хотод хуримаа хийхээр товчлосон байсан юм. Гэтэл миний нөхрийн ажилладаг Зэвсэгт хүчний 167 дугаар ангид Ж.Ёндон сайд тэргүүтэй шалгалтын комиссынхон ирж таарсан ба түүнд



чөлөө олддог юм биш. Гэтэл тэр үеийн ангийн захирагч, хурандаа Я.Санжаа сайдад илтгэснээр 11-ний шөнө сайдын онгоцоор нөхөр, хүү, бид гурав Улаанбаатарт ирсэн. Нисэх буудалд буухад машин ирчихсэн тосож байлаа. Тэгээд л 12-ны өглөө Гэрлэх ёслолын ордонд хуримаа хийж байсан юм. Сайдын онгоцоор ирж хуримаа хийх боломж хэн бүхэнд олдохгүй ховор агшин учир ихэд бэлгэшээж, нандигнаж явдаг юм.

Яг тэр мөчид та юу бодож байсан бол. Хуримаа хойшлуулахаас гэж бодсон байх даа ...

-Том хүү маань төрчихсөн байлаа. Тэр үед "Энэ хүнтэй суухгүй юм байна. За нутаг буцъя, энэ цэргийнхэн ч дээ" гэж бодож байсан. Гэтэл тэр сайд, дарга нарын гаргасан шийдвэр, өөрөө цэргийн байгууллагад ажиллаад явахаар "энэ цэргийнхэн ч дээ" гэсэн бодол 360 градус эргэсэн дээ. Хэчнээн чанга хатуу дүрэм, журамтай ч хүнээ

бодсон дарга нар олон байдаг юм.

Цэргийн хүний гэргий байна гэдэг бас л тэвчээр шаардаж байжээ ...

-Тэгэлгүй яах вэ. Аль ч цаг үед цэргийн хүний гэргий нь тэдний хамгийн чухал хүмүүс нь байдаг гэж би хувьдаа боддог. Цаг наргүй, гэрийн бараа ховор хардаг хүмүүстэй хувь заяагаа холбосон учир цэргийн хүний гэргий нарт ар гэрээ авч явах, үр хүүхдээ өсгөх хүндхэн үүрэг ноогддог. Сүүлийн үед залуус олон сараар энхийг дэмжих ажиллагаанд явж байна. Энд мөн л эхнэр хүний үүрэг, үүрэх "ачаа" нэмэгдэж байна л гэж би хардаг. Найдвартай ар тал нь болж явна гэдэг их чухал шүү.

Сүүлийн асуултыг танд үлдээе ...

-Энэхүү завшааныг ашиглан "Соёмбо" сонин уншигчид болон намайг таньдаг хэн бүхэнд эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсье.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ



Дэслэгч М.Ганшир, Иргэний нисэхийн ахлах дэслэгч Г.Нармандах нар хүү, охины хамт. 1988 он

Дуу төрсөн түүх

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний "Соёмбо" сонин эрхлэгч, хурандаа Б.Отгонбаяр өөрийн уран бүтээлийн сандаа цэрэг-эх орны сэдэвт 30 гаруй дуугаа "өлгийдөж авсан" авьяаслаг нэгэн. Тэр бээр 2010 онд Зэвсэгт хүчний 123 дугаар ангид ажиллаж байхдаа Ховд аймгийн Хөгжимт драмын театрт өөрийн уран бүтээлийн "Сэтгэлээс урсах миний дуунууд" уран бүтээлийн тайлан тоглолтоо дөрвөн удаа хийсэн ба тэр жилээ Увс аймгийн Улаангом, Наранбулаг сумын иргэд, залуучууд, өсвөр үеийнхэнд эл тоглолтоо өргөн барьсан.

Мөн Батлан Хамгаалахын Их Сургуулийн Мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн тасгийн даргаар ажиллах үедээ Монгол бөхийн өргөөнд Цэргийн хөгжмийн сургуулийн захирал, Соёлын тэргүүний ажилтан, хөгжмийн зохиолч, хурандаа Т.Мөнхтунгалагийн хамтаар "Сэтгэлээс урсах бидний дуунууд" уран бүтээлийн тоглолтоо хийж амжсан.

Тэрчлэн ЗХЖШ-ын Иргэн-цэргийн харилцааны хэлтсийн даргаар томилогдсон жилээ мөн Монгол бөхийн өргөөнд өөрийн бие даасан уран бүтээлийн "Тангараг өргөсөн 30 жил-Танд өргөх миний дуунууд" цэрэг-эх орны сэдэвт уран бүтээлийн тайлангаа үзэгч түмэндээ толилуулсан ба энэхүү тоглолт нь телевизийн хэд хэдэн сувгаар нийтийн хүртээл болсон юм.

Хурандаа Б.Отгонбаяр тун саяхан Монгол Улсын гавьяат жүжигчин, пиано аккордионч, Чингэс хааны дэлхийн академийн жинхэнэ гишүүн, академич, дэд профессор Гончигийн Тэрбиштэй хамтран "Эх орон" хэмээх магтуу дууг зохиож үзэгч, сонсогч түмэндээ сонордуулахад бэлэн болоод байна.

Энэхүү дууг Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучин, дэд ахлагч Т.Жавхланнамын дуулснаар нийтийн хүртээл болгож ажээ.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

Хөгжим: МУГЖ Гончигийн ТЭРБИШ
Шүлэг: СТА Батжаргалын ОТГОНБАЯР

ЭХ ОРОН



Уудам хорвоог наран ивээгээд
Үдшийн орчлонг саран гийгүүлнэ (ээ)
Үзэсгэлэн төгөлдөр байгаль цогцлоод
Эрдэнэс баялаг нь нөөцөө дэлгээстэй

Дахилт:


Ай сайхан Монгол эх орон
Амин хайрын заяатай өлгий нутаг (аа)
Амьдран жаргахад юутай сайхан
Ашид мөнхийн диваажин минь дээ

Мөсөн болор оргилууд сүндэрлээд
Урсгал тунгалаг рашаан ундарна (аа)
Арвайн түрүү нь алтран дэлгэрээд
Үржилт сүргүүд багшран налайна (аа)

Дахилт:

Зуун зуунаар түүхээ бүтээгээд
Холын ирээдүйд зам нь тодорно (оо)
Хүмүүн зоны минь амьдрал тэгшрээд
Хөвчин дэлхийд алдар нь дуурсагдана (аа)
Дахилт:

Үндэсний бахархал, өв соёл



Хэнтий аймгийн ард түмнээс улс орноо батлан хамгаалах тухай анхаарч буй.

Хэнтий аймгийн Идэрмэг суманд улс орныг батлан хамгаалах тухай таниулсанд ард Ишжамц, Магсаржав, Лувсан нараас Япон, Манжийн этгээдээс манай улсын хилд орж ирснийг хэрхэвч хүлээхгүй, түүнд хохирсон зүйлүүд ба газар нутгаа эргүүлэн авч, тэдгээрийг шууд хөөн зайлуулваас зохино хэмээн шүүмжилжээ.

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс. "Улаан одон" сонин, 1935 оны 8 дугаар сарын 11-ний өдөр. Дугаар 51

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламг хямд нийтэлнэ.
*Зар, рекламг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонинг нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029